

ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГЫН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2021 оны 01 дүгээр
сарын 08-ны өдөр

Улаанбаатар
хот

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай, Дотоодын цэргийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, улсын онц чухал объектыг хамгаалах үндсэн чиг үүргийн хүрээнд 2020 онд дэвшүүлсэн зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаа.

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2020 онд “Удирдлагын манлайлал, алба хаагчдын мэргэжлийн ур чадвар, харилцааны соёлыг дээшлүүлнэ. Үйл ажиллагаанд технологийн дэвшлийг нэвтрүүлж, бүтээлч санал, санаачилгыг дэмжинэ” гэсэн зорилтыг дэвшүүлэн, зорилтын шалгуур үзүүлэлт, Цагдаагийн ерөнхий газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2020 оны А/01 дүгээр тушаалаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаа.

Цагдаагийн ерөнхий газрын даргын зөвлөлийн 2020 оны ээлжит 9 дүгээр хуралдаанаар цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2021 онд дэвшүүлэх зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг хэлэлцүүлэн батлуулсан.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2020 онд үйл ажиллагаанд холбогдох бодлогын 24, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 74, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хамаарах 6 баримт бичиг, захиргааны хэм хэмжээний 10 акт болон биелэлт эргэн мэдээлэх шаардлагатай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг болон холбогдох дээд шатны байгууллага, удирдлагын тушаал, зөвлөмж, албан даалгавар, үүрэг зэрэг нийт 145 баримт бичгийг хяналтад авч, жилийн эцсийн байдлаар Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд нийтлэг журмын 3.2.1-д заасан баримт бичиг болох Монгол Улсын хууль 4, Улсын Их Хурлын тогтоол 6, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол 4, Ерөнхийлөгчийн зарлиг 3, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж 5, Засгийн газрын тогтоол 41, Ерөнхий сайдын захирамж 1, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 17, Засгийн газрын албан даалгавар 2, нийт 83 шийдвэрийн 143 арга хэмжээ, зүйл заалтыг хяналтад авч, биелэлт, үр дүнг тооцон, хяналт-шинжилгээ хийн, үнэлгээ өгч, Хууль зүй, дотоод хэргийн яаманд тогтоосон хугацаанд хүргүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын хүрээнд Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 5 жилийн төлөвлөгөө, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны мөрийн хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөнд цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас тодорхой саналыг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн, тусгуулж, батлуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын зөвлөлийн 2020 оны хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчаар батлуулан, 2020 онд зөвлөлийн ээлжит 9 удаагийн хуралдаанаар бодлогын чанартай болон дээд шатны албан тушаалтан, түүнчлэн Цагдаагийн төв байгууллагын даргын шийдвэрийн хэрэгжилт, санхүү, төсөв, дотоод хяналт шалгалт, хүний нөөцийн зэрэг 25 асуудлыг хэлэлцүүлж, хуралдаанаас гарсан шийдвэр, мэдээлэл, үүрэг, ажлын чиглэлийг холбогдох анги, байгууллагад тухай бүр хүргүүлж, үр дүнг тооцон ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчаас болон Тэргүүн дэд, Дэд, Захиргааны удирдлагын газрын дарга нараас цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан нийт 95 удаагийн үүрэг, ажлын чиглэл, зөвлөмжийг боловсруулан, анги, байгууллагад хүргүүлж, хэрэгжилтийг тухай бүр тооцсон.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 141 дүгээр тогтоолоор “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр 2020-2024”-ийг баталсан бөгөөд хөтөлбөрийг 2020-2021

онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны А/110 дугаар тушаалаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Монгол Улсад Хууль зүйн алба үүсэн байгуулагдсаны 110, орчин цагийн цагдаагийн байгууллага үүсэн байгуулагдсаны 100 жилийн ой 2021 онд тохиохтой холбогдуулан бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг, дэд ажлын хэсгүүдийг Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2020 оны А/136 дугаар тушаалаар байгуулж, ойг тэмдэглэн өнгөрүүлэх бэлтгэл ажлын төлөвлөгөөг 8 бүлэг, 81 ажил, арга хэмжээтэй төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Монгол түмний уламжлалт сар шинийн баяр, Тулгар төрийн 2229, Их Монгол Улсын 814, Ардын хувьсгалын 99 жилийн ой, Үндэсний их баяр наадам, Монгол Улсын Их Хурал, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагаа, коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахал, жагсаал, цуглааны үеийн хэв журмын хамгаалалт, зохицуулалтын чиглэлээр өгөх үүрэг, ажлын чиглэлийг боловсруулан хүргүүлж, хэрэгжилтийг ханган, нөхцөл байдлын талаарх 91 удаагийн танилцуулгыг бэлтгэн, холбогдох дээд шатны байгууллага, албан тушаалтанд тухай бүр хүргүүлэн, мэдээ, мэдээллээр хангаж ажилласан.

Мөн удирдлагаас өгсөн үүрэг, дээд шатны байгууллага, албан тушаалтан, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын дагуу цагдаагийн байгууллагад шалгагдаж байгаа гэмт хэргийн талаарх 223 танилцуулга, 140 мэдээ, мэдээллийг бэлтгэн, хүргүүлсэн ба цагдаагийн төв байгууллагын даргын байгууллага, алба хаагчдад өгөх 73 мэндчилгээ, хэлэх үгийг бэлтгэн, цахим сайтад байршуулсан.

Монгол Улсын Ерөнхий сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагаа, нөхцөл байдалтай танилцах, удирдлага, алба хаагчидтай хийх уулзалтын арга хэмжээг зохион байгуулж, өгсөн үүрэг, үүргийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг тус тус боловсруулан, Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчаар батлуулж, анги, байгууллагад хүргүүлэн, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Мөн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 14 хоног тутмын шуурхай хуралдаан, Цагдаагийн ерөнхий газрын даргын зөвлөлийн гишүүдийн Даваа гараг бүрийн хуралдаан, Захиргааны удирдлагын газрын 14 хоног тутмын мэдээлэл солилцох хурлын үед хийх мэдээлэл, өгсөн үүргийн биелэлтийг тус тус нэгтгэн боловсруулж, хуралдаанаас өгсөн үүрэг, чиглэлийг цагдаа, дотоодын цэргийн холбогдох анги, байгууллагад хүргүүлэн, хэрэгжүүлэх ажлыг тухай бүр зохион байгууллаа.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, зөвлөлийн гишүүдээс Улаанбаатар цагдаагийн хүрээний цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын үйл ажиллагаа, нөхцөл байдалтай танилцах, алба хаагчдын санал, хүсэлтийг сонсох ажлыг зохион байгуулан, үр дүнгийн талаарх танилцуулга, мэдээллийг бэлтгэж, Цагдаагийн ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулан, өгсөн үүргийг хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын дунд зохион байгуулагдах буудлагын аварга шалгаруулах тэмцээний бэлтгэл ажлыг хангаж, тэмцээнийг 2020 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр Цагдаа, дотоодын цэргийн Сургалтын нэгдсэн төвийн “Нарстай” хээрийн сургалтын хэсэгт амжилттай зохион байгуулсан.

Гурав дахь жилдээ зохион байгуулагдаж байгаа энэхүү тэмцээнд 11 байгууллагын 70 алба хаагч, 4 төрлөөр өрсөлдөж, багийн дүнгээр тэргүүн болон удаах байрт Цагдаагийн ерөнхий газар, гутгаар байранд Тагнуулын ерөнхий газрын баг тус тус шалгарсан.

Сар шинийн баяр, “Олон улсын болон Монголын ахмадын өдөр”-ийг тохиолдуулан Цагдаагийн ерөнхий газрын ахмад ажилтнуудад хүндэтгэл үзүүлэх, Цагдаагийн ерөнхий газрын дарга, зөвлөлийн гишүүнээр ажиллаж байсан ахмад ажилтан, албан тушаалтнууд болон Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын генералууд, “Үйлчилгээний гавьяат ажилтан” цол, тэмдгээр шагнагдсан алба хаагчдыг хүлээн авч уулзан, хүндэтгэл үзүүлэх, Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн газрын барилгыг ашиглалтад хүлээн авах зэрэг нийт 17 ажил, арга хэмжээг холбогдох алба, нэгжтэй хамтран зохион байгуулсан.

Улсын онцгой комиссын орлогч дарга, Батлан хамгаалахын сайдын 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр баталсан “Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний салбар дундын төлөвлөгөө”-ний хүрээнд цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний танилцуулгыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргад 14 хоног тутамд нийт 17 удаа хүргүүлсэн.

Дэлхий нийтэд коронавируст халдвар /КОВИД-19/ -ын цар тахлын тархалт буурахгүй байгаатай холбогдуулан түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын бие бүрэлдэхүүнийг Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн тушаалаар өндөржүүлсэн бэлэн байдлын хоёрдугаар зэрэгт шилжүүлэн ажиллуулж байгаа ба хугацааг 12 удаа сунгасан.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн даргын 2020 оны н/07 дугаар захирамжаар Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын хамтран хэрэгжүүлэх ажлын 2020 оны нэгдсэн төлөвлөгөөнд “Цагдаа, тагнуулын байгууллага, дотоодын цэргийн албаны бэлэн байдлыг хангах, алба хаагчдын буудлагын дадлага, сургуулилтын хэрэгцээг хангах зорилгоор сум дахин цэнэглэх бага оврын үйлдвэр байгуулах, техник, тоног төхөөрөмж худалдан авах” асуудлыг нэмж тусгасантай холбогдуулан Ажлын хэсэг байгуулан холбогдох тооцоо, судалгааг гарган, танилцуулсан.

Хүний нөөцийн чиглэлээр: Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 971 тушаалаар давхардсан тоогоор 8911, Цагдаагийн ерөнхий газрын дэд болон Захиргааны удирдлагын газрын даргын 89 тушаалаар 618, нийт 1059 тушаалаар 9529 асуудлыг шийдвэрлэсэн.

Цагдаагийн ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралдааны шийдвэрээр бүтцийн өөрчлөлтөөр 576, шилжүүлэн буюу зохицуулан томилсон 969, цагдаагаас офицерын бүрэлдэхүүнд 423, нөөцөөс офицер, дадлагажих ажилтнаар 47, хүүхэд асрах чөлөө цуцалсан 42, Дотоод хэргийн их сургууль төгссөн 323, Орос, Туркийн цагдаагийн академи төгссөн 12, нийт албан тушаал дэвшүүлэн томилсон 413 ба үүнээс албаны даргаар 1, газар, хэлтсийн даргаар 47, шинээр тасаг, хэсгийн даргаар 75, чиглэлийн ахлахаар 36, ахлахаар 239, албан тушаалд жинхлэн томилсон 15, шууд томилсон 26, нөөцөөс томилсон 20, төрийн өөр байгууллагаас шилжүүлэн буюу сэлгэн томилсон 34, шүүхийн шийдвэрээр 3, албан тушаал буурсан 14, Тусгай ажиллагааны газрын болон бусад нэгжид цагдаагаар 166 алба хаагчийг тус тус томилсон.

Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, 44.2 дахь заалтаар 30, эрүүл мэндээр 3, сургуульд суралцуулахаар 162, өөрийн хүсэлтээр 82, тэтгэвэрт 110, томилсон албан тушаалд очоогүй 6, хүүхэд асрах чөлөө олгосон 78, цагдаагийн байгууллагын ёс зүйг ноцтой зөрчиж халагдсан 15, сахилгын шийтгэлээр 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр 31 алба хаагчийг тус тус албанаас чөлөөлж, 6 алба хаагчийг данс бүртгэлээс хассан байна.

Харьяа алба, нэгж байгууллагаас ирүүлсэн бүтэц, орон тоотой холбоотой санал, хүсэлтийг хүлээн авч, үндэслэл, хэрэгцээ шаардлагыг судалж, холбогдох алба, нэгжээс санал авч шийдвэрлэж ажилласнаар 2020 онд давхардсан тоогоор 121 нэгж, байгууллагын бүтэц, орон тоонд өөрчлөлт оруулсан. Тухайлбал:

Шинээр 320 орон тоо нэмэгдсэнтэй холбогдуулан Экологийн цагдаагийн алба, Дотоодын цэргийн 05 дугаар ангид “Гэрээт салбар”, Тээврийн цагдаагийн албаны Иргэний агаарын тээвэр дэх цагдаагийн хэлтэст “Гэрээт замын цагдаагийн тасаг”-ийг тус тус шинээр, Хар тамхитай тэмцэх газрын үйл ажиллагааг өргөтгөн, Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын Орон нутгийн замын хяналтын хэлтсийн Гэрээт цагдаагийн хэлтэст офицер 4, ахлагч 2, Өмнөговь аймаг дахь цагдаагийн газрын Ханбогд сум дахь цагдаагийн тасагт гэрээт офицер 2, ахлагч 2, нийт 4 орон тоог, Эрүүгийн цагдаагийн албанд ахлахын 13, чиглэлийн ахлахын 1, нийт 14 орон тоог тус тус нэмэгдүүлж, Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн 9 байгууллагаас тус бүр нэг нэг нийт 9 орон тоог /ахлагч 3, офицер 6/ татан авч Эрүүгийн цагдаагийн албаны кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэст 3 дугаар тасаг шинээр

байгуулж, харьяа нэгжүүдийн 26 орон тоог цалингийн сангийн хамт 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал Дотоодын цэргийн штабын мэдэлд түр шилжүүлж, Эргүүл, хамгаалалтын газрын Банк хамгаалах гэрээт тасагт “Харуулын цагдаа” 4 орон тоог шинээр нэмж, 2 нэгжийн болон 48 албан тушаалын нэршлийг өөрчилж /ахлагч 32, офицер 16/, 2 нэгжийн бүтэц орон тоо, цалингийн зэрэглэлийг шинэчлэн баталсан.

Хэрэг бүртгэх албаны чиг үүргийг Мөрдөн байцаах албанд шилжүүлсэнтэй холбогдуулан тус албаны албан тушаалын нэршил, чиг үүргийг өөрчилж, 210 орон тоог Мөрдөн байцаах болон Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны харьяалалд шилжүүлж, орон тоо, цол, цалингийн зэрэглэлийг шинээр тогтоосон.

Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн “Цагдаагийн ажил эрх зүй” хөтөлбөрөөр суралцаж төгссөн 155 иргэнээс 134 иргэнийг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн Б/981 дүгээр тушаалаар цагдаагийн байгууллагын офицер албан тушаалын сул орон тоонд томилж, цагдаагийн дэслэгч цол олгосон.

Монгол Улсын Засгийн газрын 86 дугаар тогтоолын дагуу аймгийн төвөөс бусад суманд 5-аас дээш жил ажилласан 135 алба хаагчид 30 сарын тэтгэмж, 9 алба хаагчийн ар гэрт буцалтгүй тусламж, цэргийн байнгын тэтгэвэр тогтоолгосон 99 алба хаагчид 36 сар, хувь тэнцүүлэн тэтгэвэр тогтоолгосон 3 алба хаагчид 18 сар, цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн 4 алба хаагчид урьдчилж 18 сар, нас барсан 1 алба хаагчийн ар гэрт 120 сар, 2 алба хаагчийн ар гэрт 60 сар, 2 алба хаагчийн ар гэрт 36 сарын тэтгэмж олгох тушаалуудыг тус тус гаргасан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Алтангадас 1, Цэргийн гавьяаны улаан тугийн одон 2, Цэргийн гавьяаны одон 9, Цэргийн хүндэт медаль 11, Хөдөлмөрийн хүндэт медалиар 4, нийт 27 алба хаагч төрийн одон, медалиар шагнагдсан.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар Хууль зүйн албаны тэргүүний ажилтан цол тэмдгээр 44, Цагдаагийн алдар тэмдгээр 133, Хүндэт жуухаар 117, нийт 294 алба хаагч яамны шагналаар, Цагдаагийн ерөнхий газрын Цагдаагийн гавьяа тэмдгээр 445, Хүндэт жуухаар 1220, мөнгөн бөгж 690, Спортын алдар 19, Эрүүгийн цагдаагийн албаны хүндэт ажилтан 17, Цагдаагийн байгууллагын хүндэт тэмдэг 2, Дотоодын цэргийн алдар 18, Цагдаагийн төлөө 13, албаны төлөө нэг 314, албаны төлөө хоёр 461, албаны төлөө гурав 566, арван тавны цагдаа 1, Монгол цагдаа тэмдгээр 107, Цагдаагийн ерөнхий газрын дарга болон Захиргааны удирдлагын газрын даргын тушаалаар сарын үндсэн цалингийн тодорхой хувиар 589, нийт 4485 алба хаагч тус тус шагнагдсан.

Соён гэгээрүүлэх, албаны сургалтын чиглэлээр: Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2020 оны А/07, А/08 А/24 дүгээр тушаалаар “Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2020 оны албаны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө”, “Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө”, “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх давтан, мэргэшүүлэх 2020 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө”-г тус тус баталж, нийт 4542 удаагийн 5688 цагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 611657, мэдээлэл, сурталчилгаа, соёл хүмүүжлийн 6405 төрлийн ажил, арга хэмжээг мэдээлэл, технологийн өргөн боломжийг ашиглан зайн болон цахим хэлбэрээр зохион байгуулж, давхардсан тоогоор 831143 алба хаагчийг хамруулан үр дүнг тооцсон.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөх холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмуудыг алба хаагчдад судлуулах, зорилгоор гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр 183 удаагийн сургалтад 16148, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр 73 удаагийн сургалтад 19282, Тээврийн цагдаагийн албаны чиглэлээр 69 удаагийн сургалтад 44207, Дотоодын цэргийн үйл ажиллагаа, улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хангах чиглэлээр 54 удаагийн сургалтад 43605, Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын чиглэлээр 78 удаагийн сургалтад 11764 алба хаагчид тус тус хамрагдаж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нутаг дэвсгэрийн төр, захиргаа, хууль хяналтын байгууллагатай хамтран 68 удаагийн сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулж, 3154 алба хаагч, 247152 иргэнийг хамруулсан.

Алба хаагчдын сургалтад зориулж 591 хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан, 959 аудио, видео бичлэг, богино хэмжээний кино бүтээж, 7956 ширхэг гарын авлага, тараах материал, бодлого, аргачлал хэвлүүлэн тарааж, сургалтад нийт 47.2 сая төгрөг зарцуулсан.

Мөн Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвд алба хаагчдыг мэргэшүүлэх, чадавхжуулах, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр 104 удаагийн зайн болон цахим сургалтад давхардсан тоогоор 15079 алба хаагчийг хамруулан, сургалтын багц кредит цаг хангуулан, гэрчилгээ олгож, иргэд, олон нийтэд чиглэгдсэн сургалтын хүрээнд олон нийтийн цагдаагийн ажилтан бэлтгэх 5 удаагийн сургалтад 241, иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны 51 удаагийн сургалтад 1534 иргэнийг хамруулж, гэрчилгээ олгосон.

Алба хаагчдын мэдлэг, ур чадвар, боловсролын түвшинг дээшлүүлэх зорилгоор Цагдаагийн байгууллагын захиалгаар Дотоод хэргийн их сургуулийн бакалаврын боловсролын эчнээ хөтөлбөрийн сургалтад 343, магистрын хөтөлбөрийн сургалтад 48, докторын хөтөлбөрийн сургалтад 10, Удирдлагын сургуульд 24, нийт 425 алба хаагчийг суралцуулж байна.

Мөн алба хаагчдын мэргэжлийн болон гадаад хэлний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, хөгжүүлэх зорилгоор гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж, БНХАУ, ОХУ, БНТУ, Тайвань, БНУУ, Австрали зэрэг 6 улсын цагдаагийн байгууллага, академи, их, дээд сургуульд боловсролын адъюнктур, доктор, магистрантур, бакалаврын сургалтад 78, АНУ, БНТУУ, БНКУ, Катар, Япон зэрэг 5 улсад богино хугацааны 6 удаагийн сургалтад 19, нийт 97 алба хаагчийг суралцуулсан.

Алба хаагчдын мэргэшлийн түвшинг ахиулах, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн яам, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Улсын Прокурорын ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн ерөнхий газар, Удирдлагын академи, Дотоод хэргийн их сургууль, Олон улсын хөгжлийн эрх зүйн болон Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, Гал голомт үндэсний хөдөлгөөн, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Наркалогийн төв, Хүний эрхийн үндэсний комисс, Жендэрийн үндэсний хороо, Хөгжлийн чимээ зэрэг нийт 17 төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран 23 удаагийн сургалтад 1295 алба хаагчийг хамруулсан.

Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, цагдаа, дотоодын цэргийн байгууллагын албан тушаал, түүнд тавигдах тусгай шаардлагыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Удирдлагын академийн Төрийн албаны сургуультай хамтран ахлах түшмэлийн мэргэшүүлэх зайн сургалтад цагдаа, дотоодын цэргийн байгууллагын удирдах албан тушаалын 183, “Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх сургалт”-д 1, Төрийн албан хаагчийн богино хугацааны сургалтад 4, Архивын мэргэшүүлэх сургалтад 2, нийт 190 алба хаагчийг тус тус суралцуулсан.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын ахлагч албан тушаалын сул орон тоог нөхөх хүний нөөцийн хэрэгцээ, шаардлагын хүрээнд "Цагдаа", "Харуулчин" албан тушаалын мэргэжил олгох сургалтыг цахимаар болон тухайн нутаг дэвсгэр хариуцсан цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагыг түшиглэн 2 удаа зохион байгуулж, 476 иргэнийг цагдаа, дотоодын цэргийн байгууллагын сул орон тоонд томилсон.

Гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр: Гадаад орны цагдаагийн байгууллага, олон улсын чиг үүрэг бүхий бусад байгууллагатай харилцан хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлийг боловсруулж, цагдаа, дотоодын цэргийн байгууллагын гадаад харилцаа, хамтын ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Гадаад улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, олон улсын байгууллагатай хамтран гадаадын улс, орнуудад болон дотооддоо зохион байгуулагдсан сургалт, семинартай холбоотой 8 удаагийн арга хэмжээнд 51, айлчлал, албан томилолт, олон улсын хурал, уулзалт, зөвлөгөөнд оролцохтой холбоотой 3 арга хэмжээнд 4, нийт 11 арга хэмжээнд 55 алба хаагчийг Бүгд Найрамдах Турк Улс, Америкийн Нэгдсэн Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Итали Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Казакстан Улсуудад гадаад томилолтоор ажиллуулахад шаардлагатай бусад дэмжлэг үзүүлж ажилласан.

Монгол Улсад суугаа гадаад улсын Элчин сайдын яамд, дипломат төлөөлөгчдийн газар, төрийн дээд байгууллага болон яамд, цагдаагийн байгууллагын харьяа нэгж, газар, хэлтэс, төвийн дарга нарт нийт 557 албан бичиг боловсруулан хүргүүлж, мөн дээрх байгууллагуудаас 973 албан бичгийг хүлээн авсан.

Үүнээс Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Гадаадын байгууллага, иргэнтэй харилцах /код131/ журам”-ын 131.4.2-д “Цагдаагийн байгууллага, албан хаагчаас дипломат төлөөлөгчийн газартай харилцах тухай хүсэлтээ цагдаагийн төв байгууллагын дарга болон Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэст бичгээр гаргаж шийдвэрлүүлнэ” гэж заасны дагуу 2020 онд Цагдаагийн ерөнхий газрын төв байр, түүний харьяа нэгжээс ээлжийн амралт болон бусад хугацаанд гадаад улсад зорчих хүсэлт гаргасан нийт 53 алба хаагчийн ажлын байрны тодорхойлолтыг гаргаж, холбогдох Элчин сайдын яамдад хүргүүлсэн.

Бүгд Найрамдах Турк Улсын Станбул хотод 2020 оны 01 дүгээр сарын 09-15-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журам хамгаалах олон улсын туршлага, цаашдын чиг хандлага” сэдэвт сургалтад 2, Америкийн Нэгдсэн Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамтай хамтран 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс 02 дугаар сарын 14-ний өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулагдсан “Мансууруулах бодисыг мөрдөн шалгах ажиллагаа” сэдэвт сургалтад 28, Бүгд Найрамдах Итали Улсын Ром хотод 01 дүгээр сарын 11-19-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх нь” сэдэвт сургалтад 2, Япон Улсын Токио хотод 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрөөс 02 дугаар сарын 22-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Эрүүгийн хэргийг мөрдөн шалгах, Олон улсын хамтын ажиллагаа” сэдэвт сургалтад 2, Бүгд Найрамдах Казакстан Улсын Алма-Ата хотод 2020 оны 02 дугаар сарын 13-24-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Интернэт технологи ашиглан мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис, мөн шинээр гарч буй сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх нь” сэдэвт сургалтад 8, Америкийн Нэгдсэн Улсын “Олон улсын зочин манлайлагч хөтөлбөр”-ийн хүрээнд тус улсад 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс 03 дугаар сарын 09-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Цахим хэрэгсэлтэй ажиллах чадвар ба хуурамч мэдээлэлтэй тэмцэх нь” сэдэвт сургалтад 1, нийт 43 алба хаагч хамрагдсан.

Америкийн Нэгдсэн Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамтай хамтран 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс 02 дугаар сарын 14-ний өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулагдсан “Мансууруулах бодисыг мөрдөн шалгах ажиллагаа” сэдэвт сургалтад 28, Дэлхийн Банк, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газартай хамтран 2020 оны 6 дугаар сарын 29-нөөс 7 дугаар сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд “Хулгайлагдсан хөрөнгө хураан авах ажлын хүрээнд санхүүгийн гэмт хэргийг мөрдөн шалгах нь” сэдэвт сургалтад 8, Оросын Холбооны Улсын Дотоод хэргийн яамны харьяа Сибирийн хууль зүйн дээд сургуультай хамтран 2020 оны 10 дугаар сарын 12-16-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Хар тамхитай тэмцэх арга зүй” сэдэвт мэргэжил дээшлүүлэх цахим сургалтад 7, нийт 43 алба хаагч дотоод сургалтад хамрагдсан.

Цагдаагийн байгууллагын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх ажлын хүрээнд гадаадын цагдаагийн байгууллага, олон улсын байгууллага, гадаад Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамдын төлөөлөгчид холбогдох албадын удирдлагатай хийх 7 удаагийн уулзалтыг тухай бүр Цагдаагийн ерөнхий газрын дарга, удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу зохион байгуулж, хэлмэрчилж ажилласан.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлыг таслан зогсоох, эрсдэлт нөхцөл байдлаас ард түмнээ хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр хичээл зүтгэл гарган ажиллаж байгаа Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Нийгмийн Аюулаас Хамгаалах Яамны хамт олонд Монголын цагдаа, дотоодын цэргийн байгууллагын бие бүрэлдэхүүнээс нэг өдрийн цалингаа хандивлах болсонтой холбогдуулан тус улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны холбогдох албан тушаалтнуудтай ярилцаж, хандив, тусламжийг олгох арга хэмжээг зохион байгуулсан.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Нийгмийг аюулаас хамгаалах яамнаас шинэ төрлийн коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахал хурдацтай нэмэгдэж байгаатай холбогдуулан хүн амыг болзошгүй аюулт өвчнөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор 225.0 сая төгрөгийн үнэ бүхий нэг удаагийн халдвар хамгаалалтын хувцас 1000,

амны хаалт 160.0 мянган, эмчилгээний зориулалттай 1000 ширхэг нүдний шилийг 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад хүлээлгэн өгөх үеийн арга хэмжээг зохион байгуулсан.

Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яамны Бүс нутгийн аюулгүй байдлын хэлтэс нь Монгол Улс дахь Америкийн Нэгдсэн Улсын бизнесийн төлөөлөлтэй цахим уулзалтыг 2020 оны 06 дугаар сарын 11-ний өдөр тус элчин сайдын яаманд зохион байгуулах үед Цагдаагийн байгууллагаас Монгол Улсын их хурлын Сонгуулийн үеийн олон нийтийн аюулгүй байдал болон коронавирус халдвар цар тахалтай холбоотойгоор Засгийн газар болон Улсын онцгой комиссын зүгээс тогтоосон хязгаарлалтын талаар мэдээлэл хийсэн.

Үйл ажиллагаатай холбоотой хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр: Эрүү, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Цагдаагийн албаны тухай, Зөрчил, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулиудын төслийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж, 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр батлуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны А/163 дугаар тушаалаар “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хөтөлбөр, төлөвлөгөө, шалгуур үзүүлэлт”-ийг батлуулж, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах Зөвлөл, анги, байгууллагын Дэд зөвлөлийн анхдугаар хуралдааныг 10 дугаар сарын 23-ны өдөр цахимаар зохион байгуулж, цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой хууль тогтоомжийн эмхэтгэлийг бэлтгэн, анги, байгууллагад хүргүүлсэн.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөөг хангах, төр, иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг гэмт халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг бэхжүүлж, иргэний ухамсар, соёлыг төлөвшүүлэх төрийн бодлогыг хангах зорилго бүхий “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлогын баримт бичиг”-ийг 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн А/250 дугаар тушаалаар батлан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.

Эрсдэлийн үнэлгээний чиглэлээр: Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд Эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал, Эрсдэлд суурилсан дотоод аудитын тогтолцоог нэвтрүүлэх сэдвээр 8 цагийн сургалтыг цахимаар зохион байгуулж, нийт 626 алба хаагчийг хамруулсан бөгөөд цагдаа, дотоодын цэргийн нийт 70 нэгжээс давхардсан тоогоор 560 эрсдэлийг тодорхойлж ирүүлснээс эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, тухайн байгууллагын хэмжээнд шийдвэрлэх боломжтой 544 эрсдэлийг бууруулах арга хэмжээг тухайн нэгж өөрийн байгууллагын Эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд тусгаж шийдвэрлэх талаар үүрэг, ажлын чиглэл, зөвлөмж хүргүүлсэн.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд эрсдэлээ үнэлсэн байгууллагуудын эрсдэлийн үнэлгээний дүнг үндэслэн цагдаагийн байгууллагын 2020 оны эрсдэлийн үнэлгээг хийж, өндөр эрсдэлтэй буюу 25 оноотой дүгнэгдсэн төсөв санхүүгийн 2, үйл ажиллагааны 5, нийцлийн 2, гадаад хүчин зүйлийн буюу давагдашгүй хүчин зүйлсийн 2, нийт 11 эрсдэлийг байгууллагад үзүүлэх нөлөөллийн түвшин, давтагдах магадлал, чанарын түвшинг харгалзаж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын дэргэдэх Дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлэхээр танилцуулга хүргүүлсэн.

Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр: Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд 2020-2023 онд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хоёр дахь үе шатанд 7 зорилтын 53 ажил, арга хэмжээ хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан, 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдөр батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан.

Хууль зүй, дотоод хэргийн яамны 2020 оны 1-4/1026 дугаар албан бичгээр ирүүлсэн “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулж, Авлигатай тэмцэх газартай хууль тогтоомжоор тогтоосон чиг үүргийн хүрээнд хамтран ажиллаж, харилцан дэмжлэг үзүүлэх, мэдээ, мэдээлэл солилцох, алба хаагчдын мэдлэг, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, ил тод нээлттэй байх, авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд албан тушаалтанд нөлөөлөх, авилгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр богино хэмжээний видео

шторк, постер, ухуулах хуудас зэргийг хийж алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудын цахим хуудаст байршуулсан.

Авлигатай тэмцэх газраас гаргасан авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн “Чи бол авлигатай тэмцэх газар”, “Авлигатай тэмцэх газар” /Mongolian Anti-Corruption Agency, “Гомдол, мэдээлэл хүлээн авах утас 110” гэсэн шторкуудыг 24 удаагийн давталттайгаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэд, олон нийтэд хүргэсэн.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдын авлига, хээл хахууль, хүнд сурталтай холбоотой мэдээллийг 24 цагийн турш “126” тусгай дугаарын утсаар хүлээн авч байгаа талаарх мэдээллийг хэвлэлийн бага хурлаар 3, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр 48 удаа иргэд, олон нийтэд хүргэсэн.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар: Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсийн удирдах албан тушаалтанд 2020 онд иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас 11579 санал, өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2668 нэгжээр буюу 18.7 хувиар буурсан бол нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 174 буюу 1.5 хувь нь санал, 11204 буюу 96.8 хувь нь өргөдөл, 201 буюу 1.7 хувь нь гомдол байна.

Нийт санал, өргөдөл, гомдлын 1121 буюу 9.7 хувь нь ажилд орох, суралцахыг хүссэн, 268 буюу 2.3 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 1694 буюу 14.6 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 2469 буюу 21.3 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 384 буюу 3.3 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 5643 буюу 48.7 хувь нь бусад өргөдөл гомдол байна.

Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад иргэд, байгууллага, алба хаагчдаас 467 санал, өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 99 нэгж буюу 17.5 хувиар буурчээ.

Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 11 буюу 2.4 хувь нь санал, 426 буюу 91.2 хувь нь өргөдөл, 30 буюу 6.4 хувь нь гомдол байгаа бол 84 буюу 17.9 хувь нь ажилд орох, суралцахыг хүссэн, 55 буюу 11.8 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 41 буюу 8.8 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 5 буюу 1.1 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 64 буюу 13.7 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 218 буюу 46.7 хувь нь бусад өргөдөл гомдол байна. Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 426 буюу 91.2 хувийг шийдвэрлэж, 41 буюу 8.8 хувь нь ажиллагаанд байна.

Мөн хугацаанд иргэдээс Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах төв”-д цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 134 санал хүсэлт, өргөдөл гомдол, талархал, ирүүлсний 111 буюу 82.8 хувийг шийдвэрлэжээ.

Хоёр. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хэрэгжилтийн талаар

2.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр: Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлж, нийгэмд эерэг хандлага төлөвшүүлэх зорилгоор хулгайлах гэмт хэргээс сэргийлэх “Дахин сэрэмжилье, дахин шалгая”, залилах гэмт хэргээс сэргийлэх “Ятгах тусам нягтал”, ковид-19 цар тахлын халдвар, учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх “Бүү сандар, бүү хуурт, бүү өг”, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчихөөс сэргийлэх “Яараад яахав дээ”, “Бид нэг амьтай”, хүүхдийн эрх хамгаалах чиглэлээр “Сүүдэр бүү тусга”, “Хичээл эхэллээ”, “Хүүхэд эрхэм хэрэглэгч”, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах “Аюулгүй ажиллагаа-амьдралын баталгаа”, алба хаагчдын сахилга, ёс зүйг дээшлүүлэх “Өнгө нэмцгээе” зэрэг нэгдсэн 17, хэсэгчилсэн 1044 арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж, үр дүнг тооцон ажилласан.

Улсын хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр 15795 сургалт, мэдээлэл, сурталчилгаа, 1341 уулзалт, хэлэлцүүлэг, ярилцлага, 251 өдөрлөг, 146 уралдаан тэмцээн зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 13353108 иргэнийг хамруулж, цахим орчинд 43635 мэдээлэл, зурагт видео, контент байршуулж, олон нийтийн газар, зах, худалдааны төв, нийтийн тээвэр, орон сууцны лифтэнд 1879732 ширхэг гарын авлага, зурагт хуудас, зөвлөмж тараан байршуулж, 16934 удаа нэгдсэн үзлэг шалгалт зохион байгуулж, урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг

арилгуулахаар иргэн, хуулийн этгээдэд 20603 мэдэгдэл өгч, 18065 буюу 8,6 хувьд нь хариу авч үр дүнг тооцсон байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа болон зохион байгуулж буй ажлын талаар мэдээ, мэдээлэл бэлтгэж, давхардсан тоогоор 5729 телевиз, 1873 радио, 729 сонин хэвлэлд ярилцлага, мэдээлэл өгч, цахим хуудсанд 43635 мэдээлэл, зурагт, видео контент байршуулсныг давхардсан тоогоор 114787728 хүнд хүрсэн байна.

Хүүхэд хамгааллын үйл ажиллагааг сайжруулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэхэд олон улсын байгууллагуудын дэмжлэг, туслалцааг авах, хамтран ажиллах зорилгоор Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан, Европын холбоо, Дэлхийн зөн-Монгол, JCI-Монгол, Гүүд неборос, Японы хүүхдийг ивээх сан зэрэг хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагуудтай удирдлагуудын түвшинд уулзалтуудыг зохион байгуулж, хамтын ажиллагааг өргөжүүлэх, үе шаттай төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр харилцан тохиолцсон.

Хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гудамж талбайд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах, хүүхэд гэмт хэрэг, зөрчилд өртөж болзошгүй эмзэг цэгүүдийг иргэд, олон нийтийн оролцоотой хяналтад авах зорилгоор “Хүүхэд хамгаалагч” төсөл хэрэгжүүлэх талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Цагдаагийн ерөнхий газар хамтран ажиллах “Санамж бичиг” байгуулж, төслийг хэрэгжүүлсэн.

2.2.Эрүүгийн цагдаагийн албаны чиглэлээр: Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын Эрүүгийн цагдаагийн албаны харьяа нэгжүүд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 32135 гомдол, мэдээллийг хүлээн авч шалган, нийт гомдол мэдээллийн 29342 буюу 91.3 хувийг шийдвэрлэж, үлдэгдэл 2793 гомдол, мэдээлэлд шалгалтын ажиллагаа явуулж байна.

Хэрэг бүртгэлтийн 46503 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 9550 хэргийн эзэн холбогдогчийг олж тогтоон, яллагдагчаар татах саналтай мөрдөн байцаалтад, 17528 хэргийг хаах, 639 хэргийг харьяаллын дагуу шилжүүлэх, 95 хэргийг нэгтгэх саналтай тус тус прокурорт хүргүүлж, нийт хэргийн 27812 буюу 58.4 хувийг шийдвэрлэн, үлдэгдэл 18691 хэрэг бүртгэлтийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

Үүний 12692 буюу 67.7 хувь нь нийслэлийн дүүргүүд дэх цагдаагийн хэлтсийн эрүүгийн цагдаагийн тасагт, 294 буюу 1.5 хувь нь төвийн газар, хэлтсүүдэд, 5765 буюу 30,8 хувь нь орон нутаг дахь цагдаагийн газрын эрүүгийн цагдаагийн тасгуудад тус тус шалгагдаж байна.

Тус албаны зохион байгуулалтын бүтцийн газар, хэлтсүүд иргэд, байгууллагаас 561 гомдол, мэдээлэл хүлээн авч шалган, хэрэг бүртгэлтийн 591 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 87 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай, 150 хэргийг хаах, 64 хэргийг харьяаллын дагуу шилжүүлэх, 95 хэргийг нэгтгэх саналтай тус тус прокурорт шилжүүлж, нийт 396 хэрэг буюу 67.0 хувийг шийдвэрлэн, үлдэгдэл 195 хэрэг ажиллагаанд байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, бууруулах, хэргийн шийдвэрлэлтийг ахиулах чиглэлээр чиглэлээр нөхцөл байдлын судалгаанд үндэслэн тус албанаас нэгдсэн болон хэсэгчилсэн 27 арга хэмжээ зохион байгуулж, үр дүнг тооцсон.

2.3.Мөрдөн байцаах албаны чиглэлээр: Тус албаны бүтэц орон тооноос Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсийн 14 орон тоог Экологийн цагдаагийн албанд шилжүүлж, Тусгай субъектийн үйлдсэн хэрэг мөрдөн шалгах хэлтэст Эрүүгийн цагдаагийн тасгийг 5 орон тоотойгоор байгуулсан.

Мөн Хэрэг бүртгэх алба татан буугдсантай холбогдуулан тус албанд Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсийг 8 алба хаагчтайгаар байгуулж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын Мөрдөн байцаах тасгуудад 116 орон тоог нэмж баталсан.

Улсын хэмжээнд иргэн, хуулийн этгээдээс гэмт хэргийн шинжтэй 23356 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгасныг өмнөх онтой харьцуулбал 2873 нэгжээр буюу 12.3 хувиар өссөн. Нийт шалгасан гомдол, мэдээллийн 9435 буюу 40.4 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 12959 буюу 55.4 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзан, 318 буюу 1.3

хувийг харьяаллын дагуу шилжүүлж, нийт шалгасан гомдол, мэдээллийн 22712 буюу 97.2 хувийг шийдвэрлэсэн ба шийдвэрлэлт өмнөх оноос 1.6 хувиар буурсан байна.

Цагдаагийн байгууллага 2020 оны эхний 11 сард 71518 хэрэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 27734 хэрэг буюу 38.7 хувь нь Мөрдөн байцаах албанд шалгагдаж, урьд оны үлдэгдэл 7805, 2020 онд шинээр дугаар авсан 18136, түдгэлзүүлснээс сэргээсэн 74, хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 1719 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан.

Энэ хугацаанд хэрэг бүртгэлтийн 27734 хэрэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан мөрдөн шалгах ажиллагаа явуулсан нь өмнөх оноос 598 буюу 2.1 хувиар буурсан. Нийт шалгасан хэргийн 6886 хэрэг буюу 24.8 хувийг хааж, 9815 хэрэг буюу 35.4 хувийг эрүүгийн хэрэг үүсгэн, яллагдагчаар татаж, 466 хэрэг буюу 1.6 хувийг бусад хэрэгт нэгтгэн, 120 буюу 0.4 хувийг бусад газарт шилжүүлэн, нийт шалгасан хэргийн 22993 хэрэг буюу 82.9 хувийг шийдвэрлэсэн нь өмнөх оноос 3.4 хувиар өссөн дүнтэй байна.

Мөрдөн байцаалтын 16126 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан нь өмнөх оноос 850 буюу 5.5 хувь өсч, нийт шалгасан хэргийн 10472 буюу 64.9 хувийг шүүхэд шилжүүлж, 2689 буюу 16.6 хувийг хэрэгсэхгүй болгон, 2480 буюу 15.3 хувийг нэгтгэн, нийт шалгасан хэргийн 15641 буюу 96.9 хувийг шийдвэрлэсэн нь өмнөх оноос 0.4 хувиар, прокуророос 1114, шүүхээс 297 хэрэг буцсаныг өмнөх онтой харьцуулбал прокуророос буцсан хэрэг 210 буюу 18.4, шүүхээс буцсан хэрэг 10 буюу 3.8 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн улмаас иргэн, хуулийн этгээдэд учирсан 612.0 тэрбум төгрөгийн хохирлын 274.0 тэрбум төгрөг буюу 44.7 хувийг мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлж, 35.0 тэрбум төгрөгийн эд хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх онтой ижил түвшинд байна.

Түдгэлзүүлсэн хэрэг албаны хэмжээнд 26 байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 17 хэргээр буюу 52.9, нийт гэмт хэргийн илрүүлэлт 46.5 хувьтай байгааг өмнөх онтой харьцуулбал 3.4 хувиар тус тус өссөн.

2.4.Экологийн цагдаагийн албаны чиглэлээр: Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг дээшлүүлэх чиглэлээр Байгаль орчин, аялал жуулчлалын, Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн яам, Нийслэлийн байгаль орчны газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газар, Туул голын сав газрын захиргаатай 2020 онд хамтран ажиллах төлөвлөгөө, Монголын байгаль орчны иргэний зөвлөл, Лондонгийн амьтан судлалын нийгэмлэгийн Монгол дахь төлөөлөгчийн газар, Монголын бичил уурхайн нэгдсэн “Дээвэр” холбоотой хамтран ажиллах “Санамж бичиг” байгуулсан.

Иргэн бүрт байгаль дэлхийгээ хайрлан хамгаалж, байгаль орчинтойгоо зохицон амьдарч ирсэн үндэсний өв уламжлалаа шинжлэх ухаан, инновац, технологийн ололтод тулгуурлан, бүх нийтийн экологийн боловсролыг дээшлүүлэх, байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, байгаль, эх дэлхийгээ хамгаалах зөв дадал хандлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор 2020-2023 онд хэрэгжүүлэх “Байгаль эн тэргүүнд” төслийг боловсруулж, хэрэгжилтийг ханган ажилласан.

Хүрээлэн байгаа орчныг хамгаалах, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, байгаль экологид учрах хохирлыг бууруулах чиглэлээр 10 нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулсан.

Байгаль орчин, аялал, жуулчлал, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай хамтран холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, олборлолтын үйл ажиллагааны улмаас эвдэгдсэн талбайн хэмжээг тогтоон, нөхөн сэргээлтийг холбогдох этгээдээр зохих журмын дагуу хийлгүүлэх зорилгоор “Нөхөн сэргээлт-2020” ерөнхий арга хэмжээг зохион байгуулж, улсын хэмжээнд эвдэгдсэн 30.790 га талбайг тогтоосноос 3148 га талбайд нөхөн сэргээлт хийлгүүлсэн.

Ой, хээрийн түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэх, шуурхай шалгаж, шийдвэрлэх зорилгоор “Ой хээрийн түймэр” хэсэгчилсэн арга хэмжээг 2020 оны 04, 05 дугаар саруудад улсын хэмжээнд зохион байгуулж, орон нутгийн Онцгой байдлын хэлтэс, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Тусгай хамгаалалтын газар болон нутгийн иргэдийн хамт нийт 39 удаагийн эргүүл, шалгалтыг 1019 хүн,

хүчтэйгээр зохион байгуулж, иргэд, олон нийтэд 15450 санамж, сэрэмжлүүлэг, ухуулгын хуудас бэлтгэн тарааж, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх 8 самбарыг байршуулсан.

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А/166 дугаар тушаалаар баталсан журмын хэрэгжилтийг хангах, мод, ургамал, түүний олон янз байдлыг хамгаалах, нөөцийг зохистой ашиглаж байгаа байдалд хяналт шалгалт хийх зорилгоор “Богдхан уул”, “Самар” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, арга хэмжээний хүрээнд 25 тонн самрыг хамгаалалтын бүсээс гаргаж, Богдхан уул, Хан хэнтийн дархан цаазат газарт самар түүж байсан 635 иргэний үйлдлийг таслан зогсоож, 114 тээврийн хэрэгсэл, 93 отгийг буулган, 60 шуудай самрыг байгальд нь устгах арга хэмжээ авсан.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтран химийн хорт болон аюултай бодисыг импортлох, тээвэрлэх, худалдах, хадгалах, ашиглах, ажиллагаанд хяналт шалгалт хийх, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох, илрүүлэх, судалгаа, дүн шинжилгээ хийж нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор “Бодис-2020” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, арга хэмжээний хүрээнд улсын хэмжээнд 124 аж ахуйн нэгж, байгууллагад давхардсан тоогоор 281 төрлийн 2.004.951 тонн /хуурай/, ашиглах хугацаа дууссан, нэршил тодорхойгүй 1.753.932 кг /шингэн/ химийн хорт болон аюултай бодис хадгалагдаж байгааг тогтоосон.

Улсын хэмжээнд хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй нийт 1707 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь урьд оноос 946 буюу 1.2 дахин өссөн байна. Үүнээс гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 611 бүртгэгдсэнийг өмнөх онтой харьцуулахад 127 хэрэг буюу 26.2 хувиар өсч, улсын хэмжээнд бүртгэгдсэн 22506 хэргийн 2.7 хувийг эзэлж, хэргийн илрүүлэлт 53.1 хувьтай байна.

Гэмт хэргийн ангиллаар хэргийн өсөлт, бууралтыг өмнөх онтой харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 465 байснаас 587 болж, 122 хэргээр буюу 26.2, хүнд гэмт хэрэг 19 байснаас 24 болж 5 хэргээр буюу 26.3 хувиар тус тус буурсан.

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийг бүртгэгдсэн зүйлээр нь авч үзвэл, хууль бусаар мод бэлтгэх 250 буюу 40.9, хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох 229 буюу 37.5, хууль бусаар ан агнах 81 буюу 13.3, байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх 29 буюу 4.7, химийн хорт аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах 17 буюу 2.8, байгаль орчныг бохирдуулах 3 буюу 0.5, ой хээрийн түймэр тавих гэмт хэрэг 2 буюу 0.3 хувийг тус тус эзэлж байна.

Хүрээлэн байгаа орчны эсрэг нийт 303 холбогдогчтой, 7.4 тэрбум төгрөгийн хохиролтой 218 гэмт хэргийг илрүүлж, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан техник, хэрэгсэл 162, алт угаах төхөөрөмж 31, тээрэм 18, чулуу бутлагч 6 ширхэг, хууль бусаар олборлосон 6.4 килограмм алт, жонш 84 тонн, 41.6 килограмм мөнгөн ус, нэн ховор ургамлын үндэс 5.3 тонныг тус тус хураан авч битүүмжилсэн.

Энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр давхардсан тоогоор 90 алба хаагч 11 аймгийн нутаг дэвсгэрт 36 удаагийн хяналт шалгалтаар 42840 км явж, гэмт хэргийн шинжтэй 85 үйлдлийг илрүүлэн, цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах ASAP санд эрэн сурвалжлагдаж байсан оргодол 4, гэмт хэрэгт сэрдэгдсэн 61 хүн, 19 эд зүйлийг олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоож ажилласан.

2.5.Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр: Улсын хэмжээнд гарсан гэмт хэргийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад гудамж талбайд 4464 гэмт хэрэг үйлдэгдсэн нь 23.7 хувиар, олон нийтийн газарт 2145 гэмт хэрэг үйлдэгдсэн нь 43.1 хувиар буурсан, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 5325 бүртгэгдсэн нь өмнөх оноос 290 нэгж буюу 5.8 хувиар өссөн, мансуурсан үедээ үйлдэгдсэн гэмт хэрэг 236 бүртгэгдсэн нь 36 нэгж буюу 13.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Улсын хэмжээнд 243481 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаснаас гэмт хэргийн шинжтэй 62914 гомдол, мэдээлэл хүлээн авснаас 61586, зөрчлийн шинжтэй 180567 гомдол, мэдээлэл хүлээн авснаас 179838, нийт 241424 гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн.

Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж, зөрчил гаргасан 88056 хүнийг эрүүлжүүлсэн нь өмнөх оноос 10273 буюу 8.5 хувиар буурч, архины албадан эмчилгээнд 497 хүн, сайн дурын эмчилгээнд 518 хүнийг хамруулсан.

Улсын хэмжээнд иргэдийн аюулгүй байдлыг хангах, гудамж талбай, олон нийтийн газарт нийтийн хэв журам сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт давхардсан тоогоор хэв журам сахиулах эргүүлийн 4247 чиглэлд, 7753 цагдаагийн алба хаагч, 742 сонсогч, 433 олон нийтийн цагдаа, 483 урамшилт эргүүл, 453 автомашинтай үүрэг гүйцэтгэсэн.

Улсын хэмжээнд 17 аймагт хэсэгчилсэн цэрэг татлагыг зохион байгуулж, урьдчилсан эрүүл мэндийн үзлэгээр 8634 иргэн хамрагдсанаас 6940 иргэн эрүүл мэндийн болон бусад шалтгаанаар хасагдаж, 1694 иргэн тэнцэж цэргийн жинхэнэ алба хаахаар хуваарилагдсан цэргийн анги, байгууллагуудад хүргэж өгөх ажлыг зохион байгуулсан.

2020 онд урлаг соёлын арга хэмжээ 16, спортын арга хэмжээ 11, бэсрэг наадам 4, бусад арга хэмжээ 37, жагсаал, цуглаан 255, нийт 323 удаагийн нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулагдсан.

Нийслэлд 280, орон нутагт 43 удаа нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулагдах үед гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зохион байгуулагч болон оролцогч 21131 орчим иргэдийн аюулгүй байдлыг хангах хамгаалалтад 2066 цагдаагийн алба хаагч 253 тээврийн хэрэгсэлтэйгээр 770 цагийн хамгаалалтын үүрэг гүйцэтгэн ажилласан.

Нийслэлд зохион байгуулагдсан 280 удаагийн арга хэмжээг төрлөөр нь авч үзвэл: урлаг соёлын 12, спортын 4, бусад 25 арга хэмжээ, бэсрэг наадам 2, жагсаал, цуглаан 237 удаа зохион байгуулагдсанаас бүртгэгдсэн 8, бүртгэлгүй 229 удаа зохион байгуулагдаж 14086 орчим иргэд, орон нутагт зохион байгуулагдсан 43 удаагийн арга хэмжээг төрлөөр нь авч үзвэл: урлаг соёлын 4, спортын 7, бусад 12 арга хэмжээ, бэсрэг наадам 2, жагсаал, цуглаан 18 удаа зохион байгуулагдсанаас бүртгэгдсэн 8, бүртгэлгүй 10 удаа зохион байгуулагдаж 7045 орчим иргэд оролцсон.

Улсын хэмжээнд нийслэлийн Хан-Уул /5/, Чингэлтэй /1/ дүүрэг, Архангай /7/, Баянхонгор /3/, Баян-Өлгий /5/, Булган /7/, Дорнод /19/, Завхан /2/, Өвөрхангай /2/, Сүхбаатар /5/, Сэлэнгэ /4/, Төв /3/, Увс /1/, Ховд /3/, Хөвсгөл /3/, Хэнтий /3/, нийт 15 аймгийн 74 суманд 142 удаагийн ой, хээрийн гал түймэр гарч, урьдчилсан байдлаар 9549.3 га ой, 235.762 га хээр, нийт 245.311 га талбай, 2 гэр, 4 айлын өвөлжөө, 2 автомашин түймэрт өртөж, нийт 1.6 тэрбум төгрөгийн хохирол учирсан.

Улсын хэмжээнд объектын түймрийн талаар 3081 дуудлага, мэдээлэл бүртгэгдэж, 3768 алба хаагч, 1172 тээврийн хэрэгсэлтэй, хяналт шалгалтын 37 постод онцгой байдлын газрын алба хаагч нартай хамтран ажилласан нь хамтын ажиллагааны үр дүнд ахиц гарсан.

Коронавируст халдвар (КОВИД-19)-аас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр зохион байгуулсан ажлын талаар: Тусгай үүргийн захиалгат болон транзит 111 удаагийн нислэгээр БНХАУ, БНСУ, ХБНГУ, ОХУ, Турк, АНУ зэрэг улсаас нийт 21322 иргэн, төмөр замын болон авто замын хилийн боомтоор Монгол Улсын нийт 6756 иргэнийг тус тус татан авч тусгаарлан ажиглах байруудад байрлуулах үед иргэдийг тээвэрлэх, дэглэм сахиулах үеийн хамгаалалт, зохицуулалтад цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 13258 алба хаагч үүрэг гүйцэтгэсэн байна.

Цагдаагийн байгууллагаас Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу хорио цээрийн дэглэм сахиулах хугацаанд Засаг даргын захирамж зөрчсөн 358, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль зөрчсөн 8, нийтийг хамарсан урлаг, спорт, цахим тоглоом ажиллуулсан 39, хурдан морины уралдаан зохион байгуулсан 8, цахим сүлжээнд худал ташаа мэдээлэл тараасан 20, хорио цээрийн дэглэм зөрчсөн 74, тусгаарлан ажиглах байрны дэглэм, журам зөрчсөн 14, гэрээр тусгаарлан ажиглах журам зөрчсөн 8 зөрчлийг тус тус илрүүлж, нийслэл хотод 227 зөрчилд 13 хүнийг баривчилж, 116.570.000 төгрөгөөр, орон нутагт 332 зөрчилд 25 хүнийг баривчилж, 143.760.000 төгрөгөөр тус тус торгох шийтгэл оногдуулсан байна.

Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан өнгөрсөн хугацаанд төв, орон нутгийн цагдаагийн байгууллагын болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг бүхэлд нь хяналтад авах ажлын төлөвлөлтийг хийж, Улаанбаатар хотын шалган нэвтрүүлэх 9, хяналтын 51 цэг, орон нутагт хяналтын 285, сумдын хяналтын 630 цэгээр нутаг дэвсгэрийн авто замуудыг бүрэн хяналтад авч ажилласан.

Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссын хуралдаанаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас тусгайлан тоноглогсон чанга яригчтай авто эргүүлийн 65, Замын цагдаагийн газрын 54 автомашинаар 7 хоногт 2-3 удаа коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийг бэлтгэн хүргэж, гудамж талбайд зорчихдоо амны хаалтаа тогтмол зүүх, нус цэр, шүлсээ хаяхгүй байх, бага насны хүүхдийг олон нийтийн газарт дагуулж явахгүй байх, шаардлагагүй тохиолдолд олон хүнтэй газар зорчих, бага насны хүүхдийг гадаа тоглуулахгүй гэрийн дэглэм сахих, эрүүл мэндийн байгууллагаас өгч байгаа зөвлөмжийг дагаж мөрдөхийг иргэд, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан.

Улсын онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор Сэлэнгэ аймгийн Сүхбаатар, Алтанбулаг сумдад хорио цээрийн дэглэм сахиулах, цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдал, замын хөдөлгөөний зохицуулалт, хамгаалалт, хяналт шалгалтын чиглэлээр үүрэг гүйцэтгэх алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын алба хаагчдыг оролцуулсан “Түр хүрээ”-г Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/280 дугаар тушаалаар байгуулан, хорио цээрийн дэглэм сахиулан ажиллахад мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллалаа.

Зөрчил шалгах, мэргэжил арга зүйн чиглэлээр: Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас цагдаагийн байгууллагад нийт 243481 гомдол, мэдээлэл ирүүлснээс зөрчлийн шинжтэй 179838, гэмт хэргийн шинжтэй 61586 байгаа бөгөөд мэдээллийн нэгдсэн санд 2237844 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оноос 273962 зөрчил буюу 14.0 хувиар өсч, учирсан хохирлын 93.9 хувийг нөхөн төлүүлсэн байна.

Бүртгэгдсэн зөрчлийн 1727661 буюу 77.2 хувь нь нийслэлд, 510183 буюу 22.8 хувь нь орон нутагт байгааг төрлөөр авч үзвэл, олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явсан 78786, төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулсан 26, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчсөн 1977261, худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчсөн 4.221, бусад 69249 зөрчлүүд байна.

Нийт 2232429 зөрчлийг шалгаж шийдвэрлэснээс 2110792 иргэн, 85578 хуулийн этгээдэд 63.4 тэрбум төгрөгийн торгох, 20439 иргэнд эрх хасах, 15620 иргэнд баривчлах шийтгэл тус тус оногдуулж, согтуугаар 54886, бүлэглэн 187, эмэгтэй хүн оролцсон 5857, хүүхэд оролцсон 417, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 9786 зөрчил тус тус бүртгэгдсэн.

Хүрээлэн буй орчны хяналтын чиглэлээр: Агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа дулаан үйлдвэрлэх, түгээх зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөлтэй 100 кВт-аас дээш хүчин чадалтай 20 байгууллага, аж ахуйн нэгжийн 78 халаалтын зуух, утааны шүүлтүүр суурилуулсан 202 байгууллага, Агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журамд зааснаар холбогдох байгууллагаас олгосон зөвшөөрлийн бичгийг үндэслэн аж ахуйн нэгжийн 286 халаалтын зууханд хэрэглэгдэх 99.913,94 тонн түүхий нүүрсийг 3916 тээврийн хэрэгслээр нэвтрүүлэх тээвэрлэлт, түүхий нүүрсийг хэрэглэхийг зөвшөөрсөн Нийслэлийн дүүргүүдийн 5 хорооны хэрэглэгчдэд 34.605,7 тонн түүхий нүүрс 1368 тээврийн хэрэгслээр нэвтрүүлэхэд, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 305 дугаар тушаалаар баталсан чиглэлээр агаарын чанарыг сайжруулах бүсээр 1345 тээврийн хэрэгслээр 38.390,4 тонн түүхий нүүрсний дамжин тээвэрлэлтэд хяналт тавьж ажиллаа.

Агаарын чанарыг сайжруулах бүсэд зохих зөвшөөрөлгүй нэвтрүүлсэн болон нэвтрүүлэхээр тээвэрлэсэн түүхий нүүрсийг шийдвэрлэх Нийслэлийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн “Түүхий нүүрсний тээвэрлэлт, хэрэглээнд хяналт тавих тухай” А/1152 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, зохих

зөвшөөрөлгүй 70.3 тонн түүхий нүүрсийг Амгалан дулааны станцад төвлөрүүлэн, зөрчлийг Нийслэлийн мэргэжлийн хяналтын газарт шилжүүлж шийдвэрлүүлсэн байна.

Захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 10 аж ахуйн нэгжийн 57 объектын 127 уурын зуухны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, Нийслэлийн Захирагчийн ажлын албанаас 2019 онд олгогдсон зөвшөөрлөөр түүхий нүүрс хэрэглэсэн, өнжмөл түүхий нүүрсийг шатааж хэрэглэсэн, зөвшөөрөлгүй түүхий нүүрс хэрэглэсэн зэрэг зөрчлийг илрүүлэн 247,92 тонн түүхий нүүрсийг Амгалан дулааны цахилгаан станцад төвлөрүүлэн, 9 аж ахуйн нэгжийн зөрчлийг шийдвэрлүүлэхээр Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газарт шилжүүлэн, Зөрчлийн тухай хуульд зааснаар 18.0 сая төгрөгийн торгох шийтгэл оногдуулсан.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Цагдаагийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга нарын хамтран баталсан удирдамжийн дагуу агаарын чанарыг сайжруулах бүсэд агаар бохирдуулагч эх үүсвэр ашиглан үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын түүхий нүүрсний хэрэглээ, татан авалт, гэр хорооллын хороодын нутаг дэвсгэрт иргэд хууль бусаар түүхий нүүрс хэрэглэсэн, хадгалсан эсэхэд нийслэлийн 6 дүүргийн 122888 өрхөд хяналт шалгалт хийж 20 өрхөөс 4.6 тн өнжмөл түүхий нүүрс илрүүлэн, зохих журмын дагуу шийдвэрлэсэн. Арга хэмжээнд цагдаа, онцгой, мэргэжлийн хяналтын байгууллагын 2433 алба хаагч, ажилтан оролцсон.

Шалган нэвтрүүлэх цэгт үүрэг гүйцэтгэж буй алба хаагчид зохих зөвшөөрөлгүй бугын чив 5, тул загас 21, чонын эрхтэн 5, янгирын эвэр 32, зэрлэг гахайн мах 7, алтайн хойлог 7, ховор ургамлын жагсаалтад орсон алтайн барагшун 20 тн, хонин арц 917,5, хунчир 250, алтангагнуур 10, ногоон хаш 40, өнгөт чулуу 10, гөлтгөнө чулуу 128,1, хонгорзалаа, хурган чих, зад могойн хор, боролзгоны шар цэцэг, эгүүшин, гишүүний үндэс, бэр цэцэг гэх 7 төрлийн ургамал, химийн бодис 250, говийн өнгөт чулуу 10 кг, хар шороо 16 тн, эртний эдлэл гэх данх, цөгц, эх сурвалж тодорхойгүй 64 ширхэг нүүрсэн яндан, 120 л дизель түлш, зохих зөвшөөрөлгүй 120 метр куб мод, гарал үүслийн гэрчилгээгүй адуу 214, үхэр 26, тэмээ 9, хонь, ямаа 162 толгойг тээвэрлэсэн 502 зөрчлийг илрүүлэн, харьяалах нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад хүлээлгэн өгч, шалгуулсан.

“Байгалийн голомтот тарваган тахал болон хүн, малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх” хяналт шалгалтын арга хэмжээний хүрээнд 31 иргэн 134 нойтон тарвага тээвэрлэсэн зөрчлийг илрүүлж, Зоонозын өвчин судлалын үндэсний төвд хүлээлгэн өгсөн.

Сайжруулсан шахмал түлшийг зөв хэрэглэх, угаарын хийн хордлогод өртөхөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны даргын баталсан удирдамжийн дагуу “Яндангаа хөөлье” аяны хэвлэлийн бага хурлыг 2020 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулж, Монголын Үндэсний олон нийтийн радио телевиз, Өлзий, Эх орон, Парламент, Масс, 25 дугаар суваг телевизүүд, Ikon.news, BPR Itoim, Ergelt.mn, itoim.mn, murch.mn цахим сайт, Өдрийн сонин зэрэг хэвлэл, мэдээллийн байгууллагууд оролцож, аяныг иргэд, олон нийтэд сурталчилсан.

Эргүүл, хяналт шалгалтын чиглэлээр: Нийслэлийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг 363 эмзэг цэг, 19 томоохон зах худалдааны төв, үзэсгэлэн худалдаа явагдаж буй 13 газар, гудамж, талбайд давхардсан тоогоор авто эргүүлийн 1458 чиглэлд 5832, явган эргүүлийн 709 чиглэлд 4063 алба хаагч, 4253 хэв журмын урамшилт эргүүл, 1755 олон нийтийн цагдаа үүрэг гүйцэтгэж, 36 гэмт хэрэг илрүүлж, хүний эрүүл мэндэд хохирол учруулах 19 гэмт хэргийг таслан зогсоож, зөрчил гаргасан 8016 хүнд Зөрчлийн тухай хуульд зааснаар 181250.0 мянган төгрөгийн торгох шийтгэл оногдуулж, архидан согтуурсан 5971 хүнийг эрүүлжүүлж, 3459 хүнийг ар гэр асран хамгаалагчид нь хүлээлгэн өгч ажилласан.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагааг идэвхжүүлснээр 456 олон нийтийн цагдаа, урамшилт эргүүлд 987 иргэн ажилласан.

Орон нутгийн хэмжээнд согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгж, байгууллага, төвлөрсөн захуудад хориглосон үйлчилгээ явуулахгүй байх

талаар орон нутгийн Засаг дарга нараас гаргасан захирамжийн дагуу 1245 худалдааны төв, 405 зах, согтууруулах ундаагаар үйлчилдэг 3700 цэг, согтууруулах ундаа худалдан борлуулдаг 10102, үйлчилгээний 7677 газар, банк, банк бус санхүүгийн 2132 байгууллага, 800 ломбард, 651 сүм, хийд, 410884 тээврийн хэрэгсэл, 1803560 мянган хүнд үзлэг, шалгалт хийн, 46 гэмт хэрэг илрүүлж, 115 гэмт хэргийг таслан зогсоож, 7632 зөрчил илрүүлж, 4513 хүн, 643 албан тушаалтан, 7 хуулийн этгээдэд 460.806.000 төгрөгийн торгох шийтгэл оногдуулсан.

2.6.Тээврийн цагдаагийн албаны чиглэлээр: Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар "Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө", 2 дугаар хавсралтаар "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан болон түүний төрөлжсөн санг хөтлөх, уг сангаас мэдээлэл, лавлагаа өгөх журам", 3 дугаар хавсралтаар Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн хуралдаанаас гаргах зөвлөмжийг тус тус баталсан. Мөн зөвлөлийн 2020 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор "Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр /2019-2023/"-ийг хэрэгжүүлэх 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдсан, үүнтэй холбогдуулан тус албанаас улсын хэмжээнд 4 зорилтын хүрээнд 76 ажил, арга хэмжээг нэгтгэн зохион байгуулж, 60.5 хувьтай хэрэгжсэн.

Тус албаны төв, орон нутгийн удирдах албан тушаалтнуудын сургалт, зөвлөгөөнийг 2020 оны 10 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу амжилттай зохион байгуулсан.

Монгол Улсад үүрэн холбооны үйлчилгээ эрхлэн явуулж байгаа Unitel, Skytel, Gmobile, Mobicom компаниудын хэрэглэгчдийн гар утасны Nitone үйлчилгээнд шинээр зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэхэд иргэдэд нөлөөлөх зорилгоор "Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх", "Замын хөдөлгөөнд оролцохдоо утас болон түүнтэй ижил төсөөтэй зүйл хэрэглэхгүй байх" гэсэн утгатай аудио шторкийг "Lemons" дуу бичлэгийн студиэр бичүүлэн Мобикомын Nitone, Юнителийн Unimusic, Жи-Мобайлын Doremi, Скайтелын Skymelody үйлчилгээнүүдэд нэвтрүүлэн тус албаны харьяа газар, хэлтэс, нутаг дэвсгэр хариуцсан замын цагдаагийн тасаг /хэсэг/-ийн алба хаагчдын хувийн гар утас болон шалгах төхөөрөмжийн дугаарт дуудлага хүлээлгийн аяны тохиргоонд байршуулсан.

2020 оны 01 дүгээр сараас эхлэн гудамж замд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчид согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчлийг илрүүлэн, Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сангийн өргөдөл гомдлын санд тухай бүр шивж бүртгэн, өдөр тутам хяналт тавьж ажиллаж байна.

Хөшигтийн хөндийд байрлах Чингис Хаан олон улсын нисэх буудалд үүрэг гүйцэтгэх цагдаагийн хэлтсийн үйл ажиллагааг хэвийн явуулахад Иргэний нисэхийн ерөнхий газраас дэмжлэг үзүүлэн эхний ээлжид төслийн ажилчдын конторын "А" кемпээс 100 м² талбайн хэмжээтэй алба хаагчдын ажиллах өрөө, тасалгааг шийдвэрлэсэн.

Хүүхэд, явган зорчигчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор нийслэлийн 13 байршлын явган хүний гарцны дэргэд Нэт капитал ХХК-тай хамтран "Аюулгүй гарц" цацруулагчтай тугийг байршуулсан. Энэхүү тугийг үзэгдэх орчин хангалтгүй үед гарцаар гарч буй хүүхэд багачууд, явган зорчигчид хэрэглэж, жолооч нарын анхаарлыг дээшлүүлэх, гэрлийн гялбаанд орж, автомашинд мөргүүлэх, бэртэж гэмтэхээс урьдчилан сэргийлэх бодит үр дүнтэй ажил болсон.

Мөн бага насны хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд сургууль орчмын бүсэд гэрэлтүүлэгтэй гарц хийх саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсний дагуу "Гэрэлтүүлэг чимэглэл" ХХК-тай хамтран 78 сургуулийн 100 байршилд явган хүний гарц дээр тэмдэг, тэмдэглэл, хурд сааруулагч, гэрэлтүүлэг хийх ажлыг хамтран зохион байгуулж ажилласан. Энэхүү гэрэл нь зөвхөн гарц руу тусч, гарцаар гарч байгаа явган зорчигчийн үзэгдэлтийг сайжруулдаг, мөн явган зорчигч зориулалтын товч /push button/ дарж, шар гэрэл анивчуулж, жолооч нарын анхаарлыг дээшлүүлж болдгоороо давуу талтай, шинэлэг гэрэлтүүлэгтэй гарц бий болсон.

Улаанбаатар Налайх чиглэлийн авто замын эрсдэл бүхий газруудад хурд хэмжигч суурилуулж ажиллуулах зориулалттай 6 ширхэг хайрцгийг байрлуулан, хяналт шалгалтыг зохион байгуулан ажиллаж байна.

Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнтэй холбоотой осол хэрэг гарах, төмөр замын аюултай бүсийн дэглэмийг зөрчиж иргэн, мал амьтан дайрагдах зэргээр галт тэрэгний хөдөлгөөнд саад учруулсан тухай мэдээллийн дагуу ослын газарт очих бүрэлдэхүүн хэргийн газрын үзлэгийг богино хугацаанд чанартай явуулахад эд мөрийн баримтуудыг олж тогтоох, ул мөр илрүүлэх, бэхжүүлэхэд төвөөс болон удирдах албан тушаалтан шууд холбогдон, мэргэжлийн удирдлагаар хангахад “TrueConf” программыг ашиглах зайлшгүй шаардлагатай байгаа талаар Улаанбаатар төмөр замын Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөлд танилцуулснаар Vimble2S маркийн хөдөлгөөн тэнцвэржүүлэгч гарыг шийдвэрлүүлэн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тээврийн хэрэгслийн дундаж хурдыг тодорхойлох, зөрчил илрүүлэх, бүртгэх камерын хяналтын системийг төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Дорноговь, Говьсүмбэр, Дархан-Уул, Сэлэнгэ, Өмнөговь зэрэг аймгуудын авто замд 11 постыг камержуулан холбоод байна. Цаашид Албан журмын даатгагчдын холбоотой хамтран 1.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Монгол Улсын хэвтээ тэнхлэгийн дагуу нийслэлийн алслагдсан 2 дүүрэг, 6 аймгийн нутаг дэвсгэрт нийт 10 байршилд дээрх хяналтын системийг байгуулахаар төсөв хөрөнгийг шийдвэрлүүлсэн.

Тус албанаас иргэд, байгууллагаас гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 60233 дуудлага, мэдээлэл хүлээн авч шалгаснаас зам тээврийн осол, хэргийн 59900, төмөр замын аюултай бүс, зурвас газар болон төмөр замын байгууллага, аж ахуйн нэгжийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн 303, нисэх онгоцны буудлын аюултай бүс, зурвас газар болон харьяа байгууллага, аж ахуйн нэгжийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн 30 дуудлага, мэдээлэл хүлээн авснаас хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 966, зөрчлийн шинжтэй осол 19097, төмөр замын аюултай бүс, зурвас газар болон төмөр замын байгууллага, аж ахуйн нэгжийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг 41, нисэх онгоцны буудлын аюултай бүс, зурвас газар болон харьяа байгууллага, аж ахуйн нэгжийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн 8 гэмт хэрэг тус тус бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 262 хүн нас барж, 759 хүн гэмтэж, иргэд, байгууллагад 5.1 тэрбум төгрөгийн хохирол учирсан.

Тайлангийн хугацаанд нийт 1955865 захиргааны зөрчил илрүүлснээс замын цагдаагийн чиглэлээр 1897937, төмөр замын байгууллага, аж ахуйн нэгжийн нутаг дэвсгэрт 31122, нисэх онгоцны буудлын аюултай бүс, зурвас газар болон харьяа байгууллага, аж ахуйн нэгжийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн 26806 зөрчлийг илрүүлэн шалгаж шийдвэрлэсэн.

Үүнийг өмнөх онтой харьцуулахад дуудлага, мэдээлэл 8136 нэгжээр буюу 11.9, бүртгэгдсэн зам тээврийн осол 2436 нэгжээр буюу 10.8, нас барсан хүн 62 нэгжээр буюу 21.3, гэмтсэн хүн 245 нэгжээр буюу 25.5, гэмт хэрэг 261 нэгжээр буюу 21.3, иргэд, байгууллагад учирсан хохирол 12.4 тэрбум төгрөг буюу 38.6 хувиар тус тус буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож гудамж замын хөдөлгөөнд оролцсон 25686, замын хөдөлгөөнд оролцох шаардлага хангаагүй журамлагдсан 21013 зөрчил, нийтлэг үүргийн хүрээнд 2736 хэрэг, зөрчил илрүүлэн мэдээллийн санд бүртгэн холбогдох албадад харьяаллын дагуу шилжүүлсэн.

Нийслэл хотын гудамж замд байрлах замын хөдөлгөөний хяналтын төхөөрөмжөөр нийт 36637 зөрчил илрүүлснээс Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 11.9 дэх заалтыг зөрчин, чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээгээр зорчсон 24652, мөн дүрмийн 12.1 дэх заалтыг зөрчин хурд хэтрүүлсэн 7217, мөн дүрмийн 14.8 дахь заалтыг зөрчиж хориглосон газарт тээврийн хэрэгслээ байрлуулсан 3230, E-police аппликейшнээр 1538 зөрчлийг баталгаажуулж, бэлэн бус хэлбэрээр 949.250.000 төгрөгийн торгох шийтгэл оногдуулсан.

Нийт шалгаж шийдвэрлэсэн 697 гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээ авхуулахаар 279 аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөгчийн мэдэгдэл бичиж, 269 буюу 96.4 хувьд нь хариу авсан ба нийт бичсэн мэдэгдлийн 45.0 хувьд нь иргэд, жолооч нарын замын хөдөлгөөний дүрмийн болон бусад холбогдох хууль, дүрэм журмын мэдлэгийг

сайжруулах, сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах, 55.0 хувьд зам, замын байгууламж, тэмдэг, тэмдэглэл, гэрэлтүүлэг, теле хяналтын камерын чанарыг сайжруулах, хэрэгцээтэй газарт шинээр байршуулах чиглэлээр бичсэн байна.

Гэмт хэргийн улмаас 262 хүний амь нас хохирсон /үүнээс нийслэлд 75, орон нутагт 187/ нь өмнөх оноос 62 нэгжээр буюу 19.1, гэмтсэн хүн 2581 /үүнээс нийслэлд 1646, орон нутагт 935/ байгаа нь өмнөх оноос 883 нэгжээр буюу 25.5, хүүхэд өртсөн осол 528 /үүнээс нийслэлд 291, орон нутагт 237/ бүртгэгдсэн нь өмнөх оноос 166 нэгжээр буюу 23.9 хувиар тус тус буурсан эерэг үзүүлэлт гарсан.

2.7.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр: Улсын хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 1044 бүртгэгдэж, өмнөх оноос 74 хэргээр буюу 7.6 хувиар өсч, үйлдэгдсэн гэмт хэргийн 960 буюу 92.0 хувийг хөнгөн, 84 буюу 8.0 хувийг хүнд гэмт хэрэг эзэлж байгаа бөгөөд хөнгөн гэмт хэрэг 4.9, хүнд гэмт хэрэг 52.7 хувиар тус тус өссөн.

Энэ төрлийн гэмт хэргийн 50.5 хувь нь Улаанбаатар хотод, 49.5 хувь нь орон нутагт тус тус бүртгэгдсэн.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийн улмаас 16 хүн нас барж, 874 хүн гэмтэж, иргэдэд 796.9 сая төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал нас барсан хүн 9 буюу 2.3 дахин, гэмтсэн хүн 170 буюу 24.1, учирсан хохирол 203.2 сая буюу 32.2 хувиар өссөн байна.

Цагдаагийн байгууллагад 2020 оны эхний 11 сард гэр бүлийн хүчирхийллийн улмаас 9786 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 1557 буюу 18.9 хувиар, 7882 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 2153 буюу 37.6 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Зөрчил гаргасан 311 иргэнийг 40920.0 мянган төгрөгөөр торгох, 7571 хүнийг баривчлах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс иргэнийг торгосон шийтгэл 105 буюу 51.0 хувь, баривчилсан шийтгэл 2034 буюу 36.9 хувиар тус тус өссөн байна.

Гэр бүлийн хүчирхийлэл, түүний хор уршгийн талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлж, гэр бүлийн хүчирхийлэгч үйлдэгч болон хүчирхийлэлд өртөгчийн зан төлөвийг өөрчлөх, хүчирхийллийг үл тэвчих нийгмийн хандлагыг төлөвшүүлэх, нуугдмал гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг, сонирхлыг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээхэд дэмжлэг үзүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийг оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 2020 оны 03 дугаар сарын 06-ны өдрөөс 28-ны өдрийг хүртэлх хугацаанд “Хайр өвтгөдөггүй” урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг улсын хэмжээнд зохион явуулсан.

Жендэрт суурилсан хүчирхийлэл, түүний хор уршгийн талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлж, хүчирхийллийг үл тэвчих нийгмийн хандлагыг төлөвшүүлэх, нуугдмал гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг, сонирхлыг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээхэд дэмжлэг үзүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийг оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс 12 дугаар сарын 11-ний өдрийг хүртэлх хугацаанд “Яг одоо” урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулж ажилласан.

Статистик, мэдээллийн талаар: Цагдаагийн байгууллагын хэмжээнд 234481 гомдол, мэдээлэл бүртгэгдэн шалгагдсанаас гэмт хэргийн шинжтэй 61686 /25.3%/, зөрчлийн шинжтэй 179838 /73.9%/, гомдол мэдээлэл байна. Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 24506 буюу 39.1 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 36525 буюу 59,3 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзан, 555 буюу 0.9 хувийг харьяаллын дагуу шилжүүлж шийдвэрлэсэн.

Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 24441 буюу 39.7 хувийг 5 хоногт, 37145 буюу 60.3 хувийг 6-19 хоногт шийдвэрлэсэн байна.

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн талаар: Цагдаагийн байгууллагын хэмжээнд нийт 22506, Улаанбаатар хотод 14117 /62.7%/, орон нутагт 8374 /37.2%/, бусад газар /хилийн чанадад үйлдэгдсэн/ 15 /0.1%/, гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад нийт гэмт хэрэг 7505 буюу 25.0, нийслэлийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт

хэрэг 5105 буюу 26.6, орон нутгийн хэмжээнд 2356 хэрэг буюу 22.0, бусад газар /хилийн чанадад/-т 44 хэрэг буюу 74.6 хувиар тус тус буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь авч үзвэл: Эрүүл мэндийн эсрэг 21, Хүүхдийн эсрэг 12, Эдийн засгийн эсрэг 130, Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг 279, Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг 197, Авлигын эсрэг 24, Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг 481, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 966, Цэргийн албаны эсрэг 6, Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг 71, Хүний амьд явах эрхийн эсрэг 394, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 7029, Өмчлөх эрхийн эсрэг 11.960 тус тус бүртгэгдэж, өмнөх онтой харьцуулахад 8.6-94.8 хувиар буурч, Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг 137, Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг 177, Хүрээлэн байгаа орчны эсрэг 611, Соёлын өвийн эсрэг 7 гэмт хэрэг тус тус бүртгэгдэж, өмнөх онтой харьцуулахад 16,7 хувиас 2.6 дахин өссөн байна.

Улсын хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 48.6, нийслэлд 46.4, орон нутагт 52.8 хувь байгаа нь өмнөх оноос улсын хэмжээнд 5.5, нийслэл хотод 8.0, орон нутагт 0.3 нэгжээр тус тус өсчээ.

Гэмт хэргийн улмаас 61 хуулийн этгээд, 22292 иргэн хохирч, үүнээс 645 хүн нас барж, 7756 хүн гэмтсэнийг өмнөх онтой харьцуулахад нас барсан хүн 281 буюу 30.3, гэмтсэн хүн 324 буюу 4.0 хувиар тус тус буурсан байна.

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн захиргааны зөрчлийн талаар: Нийт 2237844 зөрчил шалгасныг өмнөх онтой харьцуулахад 237962 буюу 14.0 хувиар, 2232429 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулахад 276596 буюу 14.1 хувиар тус тус өсч, нийт зөрчлийн 1727661 буюу 77.2 хувь нь нийслэлд, 510183 буюу 22.8 хувь нь орон нутагт бүртгэгджээ.

Зөрчил гаргасан 2110792 иргэн, 85578 хуулийн этгээдийг 63.4 тэрбум төгрөгөөр торгох, 15620 хүнийг баривчлах, 20439 хүнийг торгох, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл тус тус ногдуулж, нийт бүртгэгдсэн зөрчлийн 2215005 буюу 99.2 хувьд цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч, 14424 буюу 0.8 хувьд шүүгч шийтгэл оногдуулсан байна.

Тайлангийн хугацаанд согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн үедээ, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 88056 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оноос 10273 буюу 10.4 хувиар буурчээ.

Мэдээлэл хүлээн авах, шуурхай удирдлагын чиглэлээр: Улсын хэмжээнд гэмт хэрэг, зөрчлийн талаарх 569093 дуудлага, мэдээлэл хүлээн авснаас зөрчлийн 401242, гэмт хэргийн 26557, сураггүй алга болсон хүн 4830, олдсон хүүхэд /хүн/ 2964, хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн 40409, зам тээврийн осол, хэргийн 93091 мэдээ, мэдээлэл бүртгэгджээ.

Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хамгаалах, холбогдох байгууллагад холбон зуучлах, дахин хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 108 тусгай дугаараас 102 тусгай дугаарт ирүүлсэн 2288 дуудлага, мэдээллийг хүлээн авч хамтран ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын нэгдсэн <http://102.police.gov> дотоод цахим хуудасны “МШУТ-ийн ШУХ 102 анхааруулж байна” хэсэгт хулгайлах гэмт хэргийн дуудлагын шийдвэрлэлтийн талаар 12, гэр бүлийн хүчирхийллийн болон зөрчлийн дуудлагын шийдвэрлэлтийн талаар 12, гэр бүлийн хүчирхийллийн дуудлагыг олон давтамжтай ирүүлсэн утасны дугаар, хаягийн 134 мэдээллийг тус тус байршуулж, хяналт тавьсан.

Мөн 102 тусгай дугаарт ирсэн хулгайн 4623, хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн 36831 дуудлагын шийдвэрлэлт, очсон хугацаанд хяналт тавьж, хулгайлах гэмт хэргийн дуудлага өгсөн 4428, хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн дуудлага өгсөн 19022, сураггүй алга болсон гэж мэдээлэл өгсөн 4280, нийт 27730 иргэнтэй утсаар холбогдож, санал хүсэлтийг шийдвэрлэж ажилласан.

2.8.Бүртгэл хяналтын чиглэлээр: Тус төвийн үндсэн үйл ажиллагаатай холбоотойгоор Цагдаа, дотоодын цэргийн байгууллага, иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас

ирүүлсэн хугацаатай 3094, хугацаа заагаагүй 443, нийт 3537 албан бичиг хүлээн авч шийдвэрлэсэн.

Иргэдээс Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхний мэдээлэл солиулахаар ирүүлсэн 514 өргөдлийг хүлээн авснаас регистрийн дугаар засах 254, овог солих 28, нэр солих 21, ургийн овог солих 18, зураг солих 25, цусны бүлэг солих 12, өршөөлийн тухай хуульд хамрагдаж эрх сэргээлгэх 31, ангилал тодруулах 51, хуучин үнэмлэх солиулах 39, архивын цахим лавлагаа авах 21, хадгаламжийн нэгжээс лавлагаа авах 14, нийт 514 өргөдөл, хүсэлтийг шийдвэрлэсэн.

Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургуулилын байгууллагын сонсогчдоос мэргэжлийн шалгалт авах чиглэлээр: Мэргэжил, хяналтын тасгаас тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургуулийн сонсогчдоос мэргэжлийн шалгалт авах хугацаа, сургууль, дамжааны нэр, шалгалт авах ангилал, байрлал зэрэг мэдээллийг багтаасан шалгалтын хуваарийг тус төвийн үйлчилгээний танхим болон www.facebook.com/licensepolice цахим хуудсанд байршуулж, холбогдох мэдээллээр ханган цахимаар шалгалт авах үйл ажиллагааг явуулж, програмд гарч байгаа алдаа, дутагдлыг арилгах ажлыг шат дараатай хийж шалгалтыг жигдрүүлэх ажлыг зохион байгуулсан.

Нийслэлийн хэмжээнд тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн болон ангилал нэмэх шалгалт 41128 иргэнээс давхардсан тоогоор замын хөдөлгөөний хууль, дүрмийн шалгалт авснаас 17844 буюу 43.0, 7290 иргэнээс жолоодлогын талбайн шалгалт авснаас 5937 буюу 81.0, 16098 иргэнээс замын хөдөлгөөний жолоодлогын шалгалт авснаас 9298 буюу 58.0 хувь нь тус тус тэнцсэн.

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсийн Замын цагдаагийн тасгаас тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн болон ангилал нэмэх давхардсан тоогоор 24378 жолоочоос замын хөдөлгөөний хууль, дүрмийн шалгалт авснаас 18704 буюу 60.0, жолоодлогын талбайн шалгалт 11119 хүнээс авснаас 9231 буюу 83.0, замын хөдөлгөөний жолоодлогын шалгалт 12195 хүнээс авснаас 8175 буюу 67.0 хувь нь тус тус тэнцсэн талаар материал ирүүлснийг мэдээллийн нэгдсэн /TPS/ санд бүртгэсэн.

Улсын хэмжээнд 21 аймаг, нийслэлийн алслагдсан 3 дүүргийн 47 сургалтын байгууллагаас 1021 удаагийн сургалт зохион байгуулж, тээврийн хэрэгсэл жолоодох эрх сэргээх 17719, зөрчлийн оноо сэргээх 1830 хүнийг хамруулан мэдээллийг ирүүлж, зурагт болон хэвлэмэл хуудас 128 төрлийн 30748, мэдээ, мэдээлэл, 52 шторк бэлтгэн ажилласан.

Жолоочийн бүртгэлийн мэдээллийн сан бүрдүүлэх, лавлагаа олгох чиглэлээр: Тээврийн хэрэгсэл жолоодох эрх олгох шалгалтад тэнцсэн үндсэн А болон В ангиллын 34371, ангилал нэмсэн 15148, E-mongolia цахим системээр 6967 иргэний материалыг хүлээн авч, жолоочийн бүртгэлийн мэдээллийн нэгдсэн /TPS/ санд баяжилт хийсэн.

Хууль зүйн сайдын 2015 оны А/189 дүгээр тушаалаар баталсан жолоодох эрхийн үнэмлэх олгох журмын дагуу шинээр жолооч болсон 29059, олон улсын жолоочийн үнэмлэх 353, гадаад иргэний үнэмлэх солих 1253, үнэмлэх солилт, нөхөн олголтоор 75497 жолоочийн мэдээллийг санд бүртгэж, нийт 119759 жолоочийн үнэмлэх, 6600 түр зөвшөөрлийг хэвлэж олгосон.

Мөн төвийн үйлчилгээний танхимаар 28239, Нийслэлийн нэг цэгийн үйлчилгээний 6 төвөөр нийт 56145 иргэнд үйлчилж, жолоочийн үнэмлэхний лавлагаа 2881 иргэнд өгч, “Монгол шуудан” ХК-иар дамжуулан 7526 захиалгын үйлчилгээ үзүүлж, нийт 110721 иргэнд үйлчилж ажилласан.

Иргэдэд үйлчлэх танхим болон Төрийн үйлчилгээний E-mongolia цахим системээр үнэмлэх нөхөн авах хүсэлт гаргасан иргэдийн мэдээллийг жолоочийн мэдээллийн нэгдсэн сан /TPS/-д шалган торгууль төлөгдөөгүй 5739 жолоочийн 404256386 төгрөгийн торгуулийг Төрийн сангийн дансанд нөхөн төлүүлсэн.

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын Замын цагдаагийн тасгаас энэ хугацаанд 19952 иргэний материал хүлээн авч, 555 албан бичиг хүргүүлж, жолоодох эрхийн талаарх лавлагаа 4180-ыг гаргаж, торгууль төлөгдөөгүй 10565 жолоочийн 1146933600 төгрөгийн торгуулийг Төрийн сангийн дансанд нөхөн төлүүлжээ.

Жолооны үнэмлэх нөхөн авах, солиулах, жолоодох эрхээ сэргээлгэх зэргээр тус төвд хандсан иргэдээс цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах “ASAP” санд эрэн сурвалжлагдаж байсан 11 иргэнийг илрүүлж холбогдох цагдаагийн газар, хэлтсийн алба хаагчдад хүлээлгэн өгсөн.

Тээврийн хэрэгсэл жолоодох эрх сэргээх, хасах: Хууль зүйн сайдын 2013 оны А/130 дугаар тушаалаар баталсан “Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих журам”-д зааснаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа байгууллагуудаас тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах нэмэгдэл ял шийтгэгдсэн 514 ялтны тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг мэдээллийн санд хасалт хийн хариуг хүргүүлж, хорих ялаар шийтгүүлж, ялаа эдэлж дууссан хугацаанаас нэмэгдэл ял тооцож эрхийг түдгэлзүүлсэн 14, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй 42 ялтанд ногдуулсан эрх хасах нэмэгдэл ялыг жолоочийн мэдээллийн сан /TPS/-ийн хар жагсаалтад шинээр жолоодох эрх олгохгүй байх төлөвөөр бүртгэсэн.

Улсын хэмжээнд жолоодох эрх хасагдсан 17572 жолоочийн мэдээллийг TPS санд бүртгэж, 23747 жолоочийн эрхийг TPS санд хүчинтэй болгож, зөрчлийн улмаас 291 жолоочийн эрхийг түдгэлзүүлж, шүүх прокурор, дээд шатны байгууллагаас ирүүлсэн шийдвэрийн дагуу 16 жолоочийн жолоодох эрхийг хугацааны өмнө сэргээсэн.

Монгол Улсын хилээр галт зэвсэг, тусгай хэрэгсэл нэвтрүүлэх зөвшөөрөл олгох чиглэлээр: Галт зэвсгийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт зааснаар худалдааны төвөөс галт зэвсэг худалдан авах 800, адилтгах хэрэгсэл 7 байгууллагын 155, улсын хилээр галт зэвсэг нэвтрүүлэх 5, гадаад орноос галт зэвсэг худалдан авах 36 хүсэлтийг хүлээн авч, уралдаан тэмцээнд оролцох 2 байгууллагын 11 тамирчны зөвшөөрлийг тус тус олгосон.

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавихтай холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр: Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль”-ийн 11, 12, 15 дугаар зүйлд заасны дагуу тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, худалдах, үйлдвэрлэх, үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэлгээний ажил үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгуулах санал авахаар хандсан 81 аж ахуйн нэгжийн материалыг хүлээн авч хянан, санал авахаар Эрүүгийн цагдаагийн албанд 70 аж ахуйн нэгжийн хүсэлтийг хүргүүлж, ирүүлсэн саналыг нэгтгэн, Уул уурхайн яаманд 68 аж ахуйн нэгжийн асуудлыг хэлэлцэх санал хүргүүлж, шаардлага хангахгүй 11 аж ахуйн нэгжид татгалзсан хариу өгсөн.

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн маршрут, замнал нийт 1242-ыг мэдээллийн нэгдсэн сангаас баталгаажуулснаар Дотоодын цэргийн 805 дугаар ангитай хамтран тээвэрлэлтийн үеийн хамгаалалтыг хэвийн зохион байгуулсан.

Аюултай ачаа тээвэрлэх зөвшөөрөл хүссэн 137 аж ахуйн нэгж, байгууллагын 607 тээврийн хэрэгсэлд үзлэг, шалгалт, дүгнэлтийн хуудсыг үндэслэн зөвшөөрөл олгож, 8 байгууллагын 92 тээврийн хэрэгслийн бичиг баримт бүрдэл дутуу шаардлага хангаагүй зөрчил дутагдал илэрснийг арилгуулсан.

Тусгай дуут болон гэрэл, дохио хэрэглэх зөвшөөрөл олгох, хяналт тавих чиглэлээр: Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн А/292 дугаар тушаал “Тусгай дуут болон гэрэл дохио тавьж хэрэглэх журам”-ын дагуу хугацаа дууссан болон шинээр зөвшөөрөл хүссэн 406 байгууллага, албан тушаалтны хүсэлт холбогдох баримт бичгийг хүлээн авч хянан 327 байгууллага, аж ахуй нэгжийн 1041 тээврийн хэрэгсэлд 0.6-1 жил хүртэлх хугацаагаар зөвшөөрөл олгосон. Үүнээс Улаан-345, Хөх-53, Хөх-Улаан-33, Ногоон-267, Шар-343-ыг олгож, дээрх журмаар эрх олгоогүй 79 байгууллага, албан тушаалтны хүсэлтэд татгалзсан хариу өгсөн.

Гэрээт харуул, хамгаалалтын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, бүртгэлийн мэдээллийн сан бүрдүүлэх чиглэлээр: Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад цагдаагийн ажил, үйлчилгээг шуурхай хүргэх, мэдээ, тайлангийн бодит байдлыг хангах зорилгоор Гэрээт харуул, хамгаалалтын байгууллагын бүртгэлийн нэгдсэн сангийн SAS /security agency services/ программ хангамжийг ашиглаж байна.

Мэдээллийн нэгдсэн санд Гэрээт харуул, хамгаалалтын 420 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэйгээс одоогийн байдлаар нийслэлд 380, орон нутагт 40 байгууллага байна. Дээрх мэдээллийн санд хүсэлтээ ирүүлсэн 253 байгууллагын мэдээллийг хянаснаас нийслэлд анхны бүртгэл 42, сунгалт 191, орон нутагт анхны бүртгэл 5, сунгалт 15 аж ахуйн нэгжид тус тус бүртгэлийн гэрчилгээний дугаар олгож ажилласан.

2.9.Хэвлэл, мэдээллийн чиглэлээр: Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, улсын онц чухал объектыг хамгаалах чиглэлээр зохион байгуулж буй үйл ажиллагааг сурталчлах, иргэдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээ, мэдээллийг түгээх ажлын хүрээнд бэлтгэдэг “Амрыг эрье”, “Цагдаагийн мэдээлэл” нэвтрүүлгийн 2020 оны 01 дүгээр сарын төлөвлөгөөнд тусгах саналыг бусад албадуудаас авч нэгтгэн, төлөвлөгөөг гарган нэвтрүүлгийг дамжуулдаг нийт 9 телевизтэй гэрээг шинэчлэн байгуулсан.

Цагдаагийн байгууллагын албан ёсны www.police.gov.mn сайтад байгууллага, алба хаагч, аян арга хэмжээтэй холбоотой 117 ярилцлага, цаг үе, үйл явдлын 218, бусад 169 нийт 504 мэдээ, мэдээллийг бэлтгэн байршуулсан нь 6869224 хүний хандалтыг авсан байна.

Хэвлэл мэдээллийн төвийн фэйсбүүк хуудаст цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын онцлог үйл явдал, аян арга хэмжээ, ярилцлага, мэдээ мэдээлэл 1717-г бэлтгэн иргэд, олон нийтэд түгээж, мэдээ, мэдээлэл, ярилцлага, постерыг давхардсан тоогоор 17987590 хүн үзэж, 4697280 хүнд таалагдаж, 5970586 удаа хуваалцаж, 2239700 удаа сэтгэгдэл үлдээсэн байна.

“Монгол төрийн цагдаа” эмхэтгэлийн 2019 оны IV улирлын дугаар, 2020 оны I, II, III улирлын дугаарыг “Адмон” ХХК-ны хэвлэлтээс тус тус 2000 ширхэг буюу нийт 8000 ширхэгийг хүлээн авч Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлаг, цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад хуваарийн дагуу тарсан.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын албаны үйл ажиллагаа, алба хаагчдыг алдаршуулах, сурталчлах ажлын хүрээнд “Бидний нэг” нэвтрүүлгийн нэгдүгээр дугаарт Нийтийн хэв журам хамгаалах, Олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Эргүүл хамгаалалтын газрын эргүүл хамгаалалтын цагдаа, цагдаагийн ахлах ахлагч М.Чоймөрөн, хоёрдугаар дугаарт Төв аймаг дахь цагдаагийн газрын Баянжаргалан сумын цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Б.Соронзонбаатар, гуравдугаар дугаарт Баянгол дүүрэг дэх цагдаагийн газрын хоёрдугаар хэлтсийн Хэв журмын офицер, цагдаагийн дэслэгч Ё.Бямбабаяр, Цагдаа жолооч, цагдаагийн дэд ахлагч А.Анхбаяр, дөрөвдүгээр дугаарт “Үйлчилгээний гавьяат ажилтан” Цагдаагийн ерөнхий газрын Автобаазын цагдаа жолооч, цагдаагийн ахлах ахлагч Н.Ганхуягийг онцолж, пэйж хуудаст байршуулан иргэд, олон нийтэд түгээсэн.

Дэлхий нийтэд тархаад буй коронавируст халдвараас иргэдээ хамгаалах зорилгоор 50 хоногийн туршид тусгаарлах байрны хамгаалалтад үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын талаарх нэвтрүүлгийг Mongol HD телевизтэй хамтран бэлтгэсэн.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын албаны үйл ажиллагаа, алба хаагчдыг алдаршуулах, сурталчлах ажлын хүрээнд “Цахим дурдатгал” 7, “10 секундийн мэдээллийн тойм” 56, “Гэмт хэргийн нөхцөл байдлын хоногийн мэдээ” 60 удаа, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, иргэд, алба хаагчдад мэдээлэл өгөх зорилгоор “Өнөөдөр” постер 10, “Police podcast” хөтөлбөрийн хүрээнд Урьдчилан сэргийлэх, Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, Нийслэлийн цагдаагийн удирдах газар, Экологийн цагдаагийн алба, Мөрдөн байцаах алба, Тээврийн цагдаагийн алба, Цагдаа, дотоодын цэргийн Сургалтын нэгдсэн төв, нийт 9 удаагийн подкаст, Баянхонгор, Өвөрхангай аймаг дахь цагдаагийн газрын хэсгийн төлөөлөгчдийн өдөр тутмын үйл ажиллагаа, ажил амьдрал, Хэнтий аймаг дахь цагдаагийн газар, Сүлд чуулга, Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн газрын үйл ажиллагаа, цаг үеийн нөхцөл байдлын талаар нийт 18 удаагийн шууд бичлэг /лайв/, 148 фото зургийг цахим хуудаст байршуулан иргэд, олон нийтэд түгээсэн.

Мөн тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, цаг үеийн нөхцөл байдал, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр давхардсан тоогоор 1048 хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж, хоногийн хугацаанд алба хаагчдаас шуурхай илрүүлсэн гэмт хэргийн талаар 91 мэдээлэл бэлтгэж давхардсан тоогоор нийт 290 сайт, тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 68 удаагийн “Өнөөдрийн сэрэмжлүүлэг”, 22 удаагийн нийтлэл бэлтгэн, мэдээллийг цахим хуудаст байршуулсан иргэд, олон нийтэд түгээсэн байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын бусад алба, хэлтэстэй хамтран цаг үеийн нөхцөл байдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 8 удаа хэвлэлийн хурал зохион байгуулж, давхардсан тоогоор 214 хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажилласан.

2.10.Зохион байгуулсан спорт, урлагийн арга хэмжээний чиглэлээр: Монгол Улсад Хууль зүйн алба үүсэн байгуулагдсаны 110, орчин цагийн Цагдаагийн байгууллагын үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг угтаж тус хорооноос 2020 онд Цагдаа, дотоодын цэргийн байгууллагуудын дунд 14, Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлаг, байгууллагуудын хэмжээнд 5, Хууль сахиулах байгууллагуудын дунд 4, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын удирдах ажилтнуудын дунд 1, ахмад ажилтнуудын дунд 4, “Их сорилго” бэсрэг наадмаар 3, Хүч цом жүдо бөхийн болон Кик боксын нээлттэй тэмцээн зэрэг нийт 33 төрлийн спортын тэмцээн, уралдаан зохион байгуулахаар төлөвлөсөн.

Түүхт ойг угтаж 2020 онд зохион байгуулагдах спортын аварга шалгаруулах тэмцээний шагналт байранд гардуулах медалийн зардал болох 9.984.000 төгрөгийг шийдвэрлүүлж, нийт 832 ширхэг медалийг “Колор Пен” ХХК-иар хийлгэн хүлээн авсан.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2019 оны “Спортын аварга шалгаруулах, тэмцээн уралдаан зохион байгуулах тухай” А/294 дүгээр тушаалаар цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд 2020 онд 14 төрлийн уралдаан, тэмцээн зохион байгуулахаас Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны нэрэмжит Жү-до, Тээврийн цагдаагийн албаны нэрэмжит Хөл бөмбөг, мөн албаны Төмөр зам дахь цагдаагийн газрын нэрэмжит Чөлөөт бөх, Дотоодын цэргийн 05, 805 дугаар ангийн нэрэмжит Дуатлон, Говьсүмбэр аймаг дахь цагдаагийн хэлтсийн нэрэмжит Шатар, Төв аймаг дахь цагдаагийн газрын нэрэмжит Хүчний гурван төрөлтийн 6 тэмцээнийг 10 дугаар сард зохион байгуулан 38 анги, байгууллагын давхардсан тоогоор 1101 алба хаагчийг хамруулсан.

Батлагдсан төлөвлөгөөний дагуу 2020 оны 11 дүгээр сард сагсан бөмбөг, олс таталт, таеквондо, боксын тэмцээн зохион байгуулах хуваарь гарсан боловч цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан хойшилсон.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдыг хөдөлгөөний дутагдалд орохоос урьдчилан сэргийлэх, ажлын байрны дасгал хөдөлгөөнийг хэвшил болгох зорилгоор ажлын байрандаа хийж болохуйц дасгал, хөдөлгөөний талаар “Дасгал хийж, дархлаагаа дэмжье” уриалга дэвшүүлж, Монголын Гирийн спортын холбоотой хамтран “Гир өргөлт”-ийн цуврал видео сургалтын 1 дүгээр хичээл /6 минут/-ийг бэлтгэн нэгдсэн систем /system.police.gov/-ийн гарын авлага хэсгийн сургалтын материал цэсэд байршуулсан.

Насанд хүрэгчид, залуучууд, өсвөр үеийн 2020 оны Улсын аварга шалгаруулах Чөлөөт бөх, Хүндийг өргөлт, Жүдо бөх, Самбо бөх, Олимпын таеквондо, Жиу-жицугийн тэмцээнд давхардсан тоогоор 100 алба хаагч, өсвөр үеийн тамирчныг бэлтгэн оролцуулж, 9 алт, 9 мөнгө, 18 хүрэл медаль тус тус хүртсэн амжилт гаргасан.

Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын “Буудлага”-ын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, тэмцээнд Цагдаагийн ерөнхий газар, Дотоодын цэргийн штаб, Авлигатай тэмцэх газар, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Тагнуулын ерөнхий газар, Хилийн хамгаалах ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Төрийн тусгай хамгаалалтын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Дотоод хэргийн их сургууль, Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн 11 байгууллагын 13 багийн 69 тамирчид оролцоноос нийлбэр дүнгээр нэг, хоёрдугаар байрт Цагдаагийн ерөнхий газрын 2, 1 дүгээр баг, гуравдугаар байрт Тагнуулын ерөнхий газрын баг тус тус шалгарсан.

Мөн тэмцээнд амжилттай оролцон Монголын Буудлага Спортын Холбооны цол зэргийн комиссын 2020 оны 01 дүгээр тогтоолоор “Буудлагын спортын 1-3 дугаар зэрэг” хүртсэн 9 алба хаагчид үнэмлэхийг олгосон.

Үндэсний бөхийн өргөөнд 2020 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулагдсан “Бүх Цэргийн цол, чимэг олгох бүх цэргийн наадам”-д цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 20 бөх оролцсоноос 2 алба хаагч 5 даван шөвгөрч “Нэмэх” чимэг, “Цэргийн начин” цол хүртсэн.

Олон Улсын ахмадын өдрийн нэрэмжит Монгол Улсын аварга шалгаруулах цуврал тэмцээнд цагдаагийн ахмадын холбооны дэргэдэх мастеруудын биеийн тамир спортын хорооны 20 ахмад тамирчид оролцож, Хөнгөн атлетикийн тэмцээнээс 3 алт, 2 мөнгө, 1 хүрэл медаль хүртэж, байгууллагын дүнгээр 3 дугаар байр, Градий гольфийн тэмцээнээс 1 алт, Ширээний теннисний тэмцээнээс 9 медаль хүртэж, байгууллагын дүнгээр 1 дүгээр байр, Софт волейболын тэмцээнд байгууллагын дүнгээр 3 дугаар байр тус тус эзэлсэн амжилт үзүүлсэн байна.

Гурав. Дүгнэлт

-Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2020 онд хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, улсын онц чухал объектыг хамгаалах үндсэн чиг үүрэг, дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаа.

-Монгол Улсын цагдаагийн байгууллагын ойрын болон дунд хугацааны тогтвортой хөгжлийг хангаж, үйл ажиллагааг боловсронгуй болгох, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох ажилд орчин үеийн менежментийн хэлбэр, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж, үр дүнг дээшлүүлэх, иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, хүний нөөцийг бэлтгэх, мэдлэг, ур чадвар, чадавхыг сайжруулах, иргэдийн аюулгүй, амар амгалан амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 141 дүгээр тогтоолоор “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”-ийг батлуулсан.

-Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөөг хангах, төр, иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг гэмт халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг бэхжүүлж, иргэний ухамсар, соёлыг төлөвшүүлэх төрийн бодлогыг хангах зорилго бүхий “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлогын баримт бичиг”-ийг 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн А/250 дугаар тушаалаар батлан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.

-Алба хаагч, ажилтны аюулгүй байдлыг хангах, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, ажиллах нөхцөл, урам зоригийг нэмэгдүүлэх зорилгоор “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хөтөлбөр, төлөвлөгөө, шалгуур үзүүлэлт”-ийг 2020 оны А/163 дугаар тушаалаар баталж, орон тооны бус зөвлөлийг байгуулсан.

-Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар цагдаа, дотоодын цэргийн байгууллагад 650 алба хаагчийн орон тоо, санхүүжилтийг шийдвэрлүүлснээс Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 152 дугаар тогтоолоор цагдаагийн байгууллагын хүүхдийн байцаагчийн орон тоог олон улсын жишигт нийцүүлэн 8000 хүүхэд тутамд 1 хүүхдийн байцаагч байхаар тогтоолгож, “Цагдаагийн байгууллагын зарим ажил, үйлчилгээ, хангалтын жишиг норматив”-д заасны дагуу 103 орон тоог шийдвэрлүүлж, цахимаар сонгон шалгаруулалтыг амжилттай явуулсан.

-Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар тогтоолоор хүрээлэн байгаа орчныг хамгаалах, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, байгаль экологид учрах хохирлыг бууруулах нэгдсэн бодлого хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий “Экологийн цагдаагийн алба”-ыг байгуулж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлснээр 2020 оны эхний 09 сарын байдлаар 526 гэмт хэрэг бүртгэгдэн, өмнөх оны мөн үеэс 55.6 хувиар өсч, илрүүлэлт 49.2 хувьд хүрсэн.

-Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Яараад яахав дээ”, “Орон нутгийн зам хөдөлгөөний соёл 2020”, “Сүүдэр бүү тусга”, “Хайр

өвтгөдөггүй”, “Ятгах тусам нягтал”, “Нягтлах тусам аюулгүй”, “Мал мах”, “Дахин шалгая, Дахин сэрэмжилье”, “Бид нэг амьтай” зэрэг нөлөөллийн олон төрлийн аян, арга хэмжээг зохион байгуулж байгаа нь иргэд, олон нийтийн талархлыг хүлээж байна.

-Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх чиглэлээр “Ногоон дуу хоолой”, “Хогоор бүү хорло”, “Ирлээ, Явлаа, Цэвэр”, “Цэнхэр алт усаа хайрлая”, “Ой модоо хайрлая” нөлөөллийн аян, “Нөхөн сэргээлт-2020” арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.

-Гэмт хэргийн гаралт сүүлийн жилүүдэд 11.4-25.0 хувиар буурч, хэргийн илрүүлэлт 0.8-8.5 нэгжээр өссөн эерэг үзүүлэлт гарсан.

-Монгол Улсын Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас хөрөнгө, санхүүжилтийг шийдвэрлүүлж, Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн газар, Налайх дүүрэг дэх цагдаагийн хэлтэс конторын шинэ барилга, Дотоодын цэргийн 805 дугаар ангийн байрлалд хугацаат цэргийн алба хаагчийг байрлуулах “Цэргийн байр”-ыг шинээр барьж ашиглалтад оруулснаар алба хаагчдын ажил үүргээ гүйцэтгэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдраа хөгжүүлэх, иргэд цэргийн алба хаах ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлсэн.

-Дэлхийн нийтэд коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахал гарч, иргэдээ урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлээр цагдаа, дотоодын цэргийн байгууллагын бие бүрэлдэхүүн ихээхэн ачаалалтай ажилласан хэдий ч Монгол Улсын Их Хурал, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн үеийн хэв журмын хамгаалалт, зохицуулалт, хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ хэвийн гүйцэтгэсэн.

Дөрөв. Цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний талаар

-“Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгуулах саналыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, хэрэгжилтийг хангах.

-Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 141 дүгээр тогтоолоор баталсан “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр 2020-2024” хөтөлбөрийг 2020-2021 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах.

-Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2021 онд дэвшүүлсэн зорилт, Цагдаагийн ерөнхий газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангах замаар гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх.

-Монгол Улсад Хууль зүйн алба үүсэн байгуулагдсаны 110, орчин цагийн цагдаагийн байгууллага үүсэн байгуулагдсаны 100 жилийн ой энэ онд тохиохтой холбогдуулан бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

-Улсын хэмжээнд бүртгэгдсэн зарим төрлийн гэмт хэрэг урьд оны мөн үетэй харьцуулахад тодорхой хэмжээнд өссөн үзүүлэлттэй байгаад дүгнэлт хийж, гэмт хэргийн гаралтыг бууруулах, илрүүлэлтийг ахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулж, үр дүнг тооцох.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР